



**БОЛОВСРОЛЫН  
ХҮРЭЭЛЭН**



Боловсролын хүрээлэнгийн захирлын  
2019 оны 9 дүгээр сарын 16 өдрийн  
ТООТ тушаалын гуравдугаар хавсралт

**БҮРЭН ДУНД БОЛОВСРОЛЫН ЗААВАЛ СУДЛАХ, СОНГОН СУДЛАХ МОНГОЛ ХЭЛ,  
ҮНДЭСНИЙ БИЧИГ, УРАН ЗОХИОЛ, МАТЕМАТИК, МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИ,  
ФИЗИК, БИОЛОГИ, ХИМИ, ГАЗАР ЗҮЙ, НИЙГЭМ СУДЛАЛ, АНГЛИ ХЭЛ, ОРОС  
ХЭЛНИЙ БОЛОН ЗААВАЛ СУДЛАХ МОНГОЛЫН ТҮҮХ, БИЕИЙН ТАМИР, ДИЗАЙН  
ЗУРАГ ЗҮЙ, ТЕХНОЛОГИ, СОНГОН СУДЛАХ ТҮҮХ, ДИЗАЙН, ТЕХНОЛОГИЙН  
САЙЖРУУЛСАН ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ СУРАЛЦАХУЙН УДИРДАМЖ**

**(Бүрэн дунд боловсрол X-XII анги)**

Улаанбаатар  
2019



**БОЛОВСРОЛЫН  
ХҮРЭЭЛЭН**

**ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН УРАН  
ЗОХИОЛЫН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ  
СУРАЛЦАХУЙН УДИРДАМЖ**

**(Бүрэн боловсролын XII анги.  
Заавал судлах ба сонгон судлах хөтөлбөр)**

Улаанбаатар  
2019

**“Монгол хэл бичиг, уран зохиол”-ын сургалтын цөм хөтөлбөр (2016)**

**Багийн ахлагч:**

Ш.Оюунцэцэг

Багшийн мэргэжил дээшлүүлэх институтийн Хэл, нийгэм хүмүүнлэгийн ухааны Сургалтын албаны дарга, магистр

**Багийн гишүүд**

**Монгол хэл:**

М.Базаррагчаа

Sc.D., профессор, МУИС, Монгол хэлний тэнхимийн багш

Б.Мөнгөнцэцэг

Ph.D., МУИС, Монгол хэлний тэнхимийн багш

Б.Оюунцэцэг

магистр, Боловсролын хүрээлэнгийн ЭША

Ц.Өнөрбаян

Sc.D., профессор, МУБИС, МСТ-ийн эрхлэгч

Ц.Туул

магистр, Шинэ-Эрин сургуулийн багш

Б.Цасанчимэг

магистр, Багшийн мэргэжил дээшлүүлэх институтийн арга зүйч

Ө.Цэндсүрэн

магистр, Нийслэлийн Боловсролын газрын мэргэжилтэн

А.Энхнаран

магистр, Байгаль эх лицей сургуулийн багш

Д.Эрдэнэсан

Ph.D., МУБИС, Монгол хэлний тэнхимийн багш

**Уран зохиол:**

Г.Галбаяр

Ph.D., дэд профессор, МУИС, Уран зохиолын тэнхимийн

эрхлэгч

Ц.Март

магистр, Нийслэлийн 11 дүгээр сургуулийн монгол хэлний багш

Г.Нандинбилиг

Ph.D., дэд профессор, МУИС, Уран зохиолын тэнхимийн багш

П.Нармандах

Ph.D., МУБИС, УЗ-ын тэнхимийн багш

П.Одсүрэн

Ph.D., Багшийн мэргэжил дээшлүүлэх институтийн арга зүйч

Д.Туяа

Ph.D., Шинэ-Эхлэл сургуулийн багш

С.Энхбаяр

ScD., профессор, МУБИС, УЗСЗ-н тэнхимийн эрхлэгч

**Үндэсний бичиг:**

Ү.Ариунболд

Ph.D., дэд профессор, МУБИС, Монгол хэлний тэнхимийн багш

Д.Баттогтох

Ph.D., Боловсролын хүрээлэнгийн ЭША

Б.Батчимэг

Нийслэлийн 23 дугаар сургуулийн багш

Н.Мөнхцэцэг

Нийслэлийн 39 дүгээр сургуулийн багш

Д.Соронзон

Ph.D., МУБИС, Монгол хэлний тэнхимийн багш

**Хөндлөнгийн шинжээч:**

А.Цог-Очир

Ph.D., профессор, МУБИС, Монгол хэлний тэнхимийн багш

Ц.Оюун

Sc.D., профессор, МУБИС, Монгол хэлний тэнхимийн багш

**Сургалтын цөм хөтөлбөрийг сайжруулсан ажлын хэсэг (2019)**

Д.Эрдэнэсан

Ph.D., МУБИС, Монгол хэлний тэнхимийн багш

А.Энхнаран

магистр, Байгаль эх лицей сургуулийн багш

Б.Сүхболд

ЕБ-ын 33 дугаар сургуулийн багш

Д.Соронзон

Ph.D., МУБИС, Монгол хэлний тэнхимийн багш

Г.Нандинбилиг

Ph.D., дэд профессор, МУИС, Уран зохиолын тэнхимийн багш

Ш.Оюунцэцэг

магистр, Багшийн мэргэжил дээшлүүлэх институтийн Хэл, нийгэм хүмүүнлэгийн ухааны Сургалтын албаны дарга

Л.Цэдэнсодном

Боловсролын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан

**Хянан тохиолдуулсан (2019)**

Л.Цэдэнсодном

Боловсролын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан

## 12 ДУГААР АНГИЙН УРАН ЗОХИОЛЫН ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ

### СУРАЛЦАХУЙН УДИРДАМЖ

(ЗААВАЛ СУДЛАХ АГУУЛГА)

НЭГ. УНШИХ ЧАДВАР

Суралцахуйн зорилт	Сурах үйл ажиллагаа	Хэрэглэгдэхүүн
<p><b>12.1a</b> Монголын орчин үеийн шилдэг уран зохиол (уянга, туульс, жүжгийн зохиол)-оос уншиж, хам сэдвийн хүрээнд тусган эргэцүүлэх замаар түүх, нийгэм, соёлын тогтвортой хөгжлийг ойлгох</p>	<p>Энэ суралцахуйн зорилтын хүрээнд сурагчид сэдэв, хам сэдвийн талаарх мэдлэг ойлголтоо өргөжүүлж, тайлан тайлбарлах чадварт суралцана. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Сонгосон зохиолын утга санааг ойлгож унших, уншсанаа ярилцахдаа бие биедээ асуулт тавих</li> <li>2. Зохиолд ямар асуудлыг дэвшүүлж тавьсныг судалж, тайлан тайлбарлах</li> <li>3. Зохиолын сэдвээс гадна түүх, нийгмийн, намтрын, соёлын, шинжлэх ухааны, гүн ухааны, угсаатны гэх мэт ямар хам сэдвийг дэвшүүлснийг судалж, тайлан тайлбарлах</li> </ol> <p>Нийгмийн хам сэдвийг судлахдаа:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Сонгосон зохиолд нийгмийн байгуулал \боолын нийгэм, феодализм, социализм, капитализм, ардчилсан нийгэм\ -ын онцлог хэрхэн туссаныг ажиглан унших</li> <li>- Тухайн үеийн нийгэм цаг үед амьдарч байгаа эрх мэдэлтэн, жирийн хүмүүсийн харилцааны онцлогийг судалж унших</li> <li>- Тухайн үеийн хүмүүсийн тэмцлийн үнэт зүйл, төрт ёсны тухай ойлголт, газар нутгийнхаа төлөө тэмцэж байгаа байдлыг тусгасан эсэхийг судалж унших</li> </ul> <p>Соёлын хам сэдвийг судлахдаа:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Тухайн цаг үеийн хүмүүс эдийн болон оюуны ямар соёл бүтээснийг судалж унших, ямар үг хэллэг, өгүүлбэрээр илэрснийг тэмдэглэх</li> <li>- Угсаатны</li> </ul> <p>Намтрын хам сэдвийг судлахдаа:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Зохиолчийн намтартай холбоотой мэдээлэл нь бичсэн зохиолтой нь хэрхэн холбогдож байгааг судлах</li> <li>- Зохиол дахь зарим утга, үг хэллэг, өгүүлбэр, эхийн хэсэг зэргийн утга нь зохиолчийн намтартай холбоотой болохыг судлах гэх мэт</li> </ul> <ol style="list-style-type: none"> <li>4. Зохиолчийн зорилго ба хам сэдвийн уншигчдад үзүүлэх үр нөлөөг үнэлэх гэх мэт</li> </ol>	<p>Ш.Сүрэнжав “Би тэнгэрийн хүү”, О.Дашбалбар “Залуус дүү нартаа хүргэх шүлэг”, П.Бадарч “Эхийн сэтгэл”, Д.Нацагдорж “Цагаан сар ба хар нулимс”, С.Дашдооров “Бууж мордох хорвоо”, Ч.Лодойдамба “Тунгалаг Тамир”, Б.Лхагвасүрэн “Тамгагүй төр”, Д.Норов “Эцсийн тушаал” гэх мэт</p>
<p><b>Багшийн анхаарах зүйл:</b> Энэ суралцахуйн зорилтын хүрээнд гурван үйл ажиллагааг санал болгосон. Үйл ажиллагаа тус бүрд дараах арга зүйг зөвлөж байна. <u>Зохиолд ямар асуудлыг дэвшүүлж тавьсныг судалж, тайлбарлах</u> 12 дугаар ангийн сурагчид зохиолыг зөвхөн уншаад, үйл явдал төдийхөнд эргэлдэх биш зохиолчийн гаргасан ил ба далд санаа, судлаач шүүмжлэгчдийн гаргасан санал дүгнэлт, үе үеийн уншигчдын санал сэтгэгдэл, өөрсдийнх нь санаа оноо гээд олон үзэл бодлын уулзвар дээр үнэлгээ дүгнэлт өгөх, түүнийгээ баталж нотлох чадварт суралцана. Өөрөөр хэлбэл зохиогчийн болон хэн нэгний бодол санааг шууд хүлээж авахаас өмнө уншихдаа эргэцүүлэн</p>		

бодож, судалж, учрыг нь олж, үнэлж дүгнэн, шүүж цэгнэж уншина гэсэн үг. Аливааг туйлын үнэн гэж хүлээж авч болохгүй, учир өөр хэн нэгэн тэс өөр юм ярьж магадгүй. Бүгдийг бие даан өөрөө үнэлж сурахад чиглүүлэх нь багшийн гол үүрэг болно.

Эхэд дэвшүүлсэн асуудлыг зөв тодорхойлоход бүтээлч уншлага зайлшгүй чухал.

Бүтээлчээр уншихад тайван, чөлөөтэй бодож эргэцүүлэх шаардлага гардаг тул уншлагад багагүй цаг хугацаа хэрэгтэй болно. Тиймээс унших зохиолын даалгаврыг хичээлийн жил болон улирлын эхэнд өгвөл зүгээр. Туршлагатай багш нар сурагчдыг хавар тарах үед унших зохиол, даалгаврыг хамтад нь өгч явуулдаг нь ихээхэн үр дүнтэй, зохиол бүтээлээ даалгаврын дагуу зуны хугацаанд сайтар уншиж судлах, түүнтэй холбоотой судалгааг сонирхон судлах боломжийг олгодог байна.

Зохиолд дэвшүүлсэн асуудлыг сурагчид өөрсдөө асуудал дэвшүүлэн шийдвэрлэх аргаар судалгаа хийж гаргахад дараах асуулт даалгаврыг өгч болно. Үүнд:

- Зохиолд юуны тухай өгүүлж, ямар асуудлыг хэрхэн хөндөж байгааг баталж нотлоорой.
- Зохиолын утга санаа нь аль аль хэсгээр илэрч байгааг тайлбарлаарай. (Өөрөөр хэлбэл зохиолын утга санааг илэрхийлсэн гол хэсэг хаана байгааг олж тайлбарлах)
- Зохиолын нэр нь сэдэв, утга санаатайгаа хэрхэн холбогдож байгааг дүгнээрэй.
- Зохиолч ямар сэдвийн хүрээнд ямар мэдээллийг өгч, ямар утгыг илэрхийлэхийг зорьсон талаар өөрийн дүгнэлтийг гаргаарай гэх мэт.

Эсвэл тухайн зохиол нь ямар сэдэвтэйг багш хэлж өгөөд яагаад гэдгийг сурагчид баталж нотолж болох юм. Жишээ нь: “Тунгалаг Тамир” романыг судлаачид түүх-хувьсгалын сэдэвтэй гэж дүгнэсэн байдаг. Яагаад гэдгийг батална уу? гэсэн даалгавар өгөөд сурагчид багаар ажиллан гүйцэтгэх хувилбар ч байж болно. Роман, жүжиг зэрэг томоохон төрлийг сурагчид уншаад зохиол бүтээлийн гүнд нэвтэрч чадаагүйгээс зөвхөн аль нэг гол баатрын үйл явдлыг барьснаар өнгөц, буруу үнэлэлт дүгнэлт өгөх алдаа гаргадгийг анхаарах. Зарим сурагч “Тунгалаг Тамир” романыг түүхэн сэдэвтэй гэж үздэг тал бий. Багш та нар түүх хувьсгалын болон түүхэн сэдэвтэй зохиолыг ялгах хэрэгтэй. Түүхэн сэдэвтэй гэдэг нь гол дүр нь бодит, түүхэн хүн байж, түүний амьдралыг уран сайхнаар дүрслэн бичсэн зохиол юм. Харин түүх хувьсгалын сэдэвтэй зохиол нь түүхэн хүний амьдралыг бус тухайн үеийн нийгэмд амьдарч байсан хүмүүсийг түүхэн нөхцөл байдалтай нь уялдуулан бичсэн онцлогтой байна. Түүхэн романы гол төлөөлөгч Ж.Пүрэв, түүхэн өгүүллэгийн гол төлөөлөгч Б.Ринчен нарын уран бүтээлийг уншуулж, түүхэн хам сэдвийн талаар судалгаа хийлгэхийг санал болгож байна. Зохиолын сэдвээс гадна түүх, нийгмийн, намтрын, соёлын, шинжлэх ухааны, гүн ухааны, угсаатны гэх мэт ямар хам сэдвийг давхар гаргасныг судалж, тайлан тайлбарлах

Энэ ангид сурагчид монголын уран зохиол уншиж байгаа учраас монголчуудын түүх, соёл, нийгэм, эдийн засаг, шашин, угсаатны зүй, бэлгэдэл зүй гэх зэргээс ямар ямар асуудал тусгасныг нарийвчлан судалж, өөрийн үзэл бодлоо илэрхийлж сурах нь энэ суралцахуйн зорилтын гол онцлог юм. Судалгаат уншлагын арга барилд сурагчдыг сургахад хам сэдэв, далд утгыг илүү анхаарч судлаачид юу гэж үзэж вэ? Яагаад? Би аль талаас нь харж байна вэ? Яагаад? гэх мэтээр маш сайн эргэцүүлэх боломжийг олгодог.

“Тодорхой нэг зохиол олон тооны жижиг сажиг явдлуудаас бүрддэг тул тэдгээр явдал бүрд өөр өөрийн гэсэн бичил утгууд бүрэлдэн агуулагдаж байдаг. Тэдгээр нь зохиолын өрнөлтийн явцад нэгдэн нийлж нэг гол сэдэв, гол утга, гол бус салбарласан утга үүсгэдэг” (Д.Галбаатар “Уран зохиол: онол, түүх, шүүмжлэл нэвтэрхий толь” УБ., 2012, 333 дугаар тал) болохыг сурагчид шинжлэн таньж, зохиолч зохиолын аль хэсэгт, ямар зорилгоор энэ хам сэдвийг оруулах болсон. Энэ нь ямар үүрэг гүйцэтгэж, ямар далд утга гаргаж байгааг үнэлж дүгнэж сурах нь чухал. Жишээ нь: Ч.Лодойдамба “Тунгалаг Тамир” романд түүх, хувьсгалын сэдэвтэй гэдгийг ардын хувьсгалын угтвар үе, ардын хувьсгалын ялалтын үе, хувьсгалын дараах бэхжилтийн үеийн нийгмийн бүх давхаргын янз бүрийн дүрүүдийн үйл амьдрал, хувь заяа дүрслэгддэгээр баталж, дүгнэж яриулах. Үүний тулд тухайн үеийн нийгэм түүхийн онцлогуудыг түүхийн хичээлийн мэдлэг дээр тулгуурлан нарийвчилж ойлгож, тайлбарлах хэрэгтэй болно гэсэн үг. Энэ зохиолд нийгэм түүхийн, намтрын, шашны, эдийн засгийн, гүн ухааны гэх мэт маш олон хам сэдвүүд сүлжилдэж, нэгдэн нийлж зохиолыг бүрдүүлж байгааг судалж дүгнэх нь сурагчдад нэлээд амаргүй, нарийвчилсан судалгаа шаарддаг тул хэд хэдэн багт хуваагдаж нэг сэдвийн дор ажиллах, улмаар хооронд нь холбоход нэлээд дөхөмтэй байдаг. Багш дараах даалгавруудаас сонгон хийлгэж болно.

- Зохиол дахь түүх, нийгэм, соёлын хүрээний үгс болон зохиолын хэсгээр дамжуулан хам сэдвийг тодруулаарай.
- Зохиолын хам сэдэв нь утга санаатай хэрхэн холбогдож байгааг дүгнээрэй.
- Тухайн дүрийн нийгмийн гарал, хүрээлэл, үүргийг судалж, хам сэдвийг тайлбарлаарай.
- Тухайн дүрийн нийгмийн гарал, хүрээлэл ...дүрд давуу тал болох уу? Сул тал болох уу? Хэрвээ өөр нийгмийн хүрээлэлд байсан бол яах байсан бэ? Яагаад?
- Зохиолд яагаад нийгмийн ...хүрээллийг дүрслэх болов? Зохиолч үүгээрээ юу илэрхийлэхийг зорьсон бэ?, ...яагаад ...хувцас өмсөж, ...үг хэлэх болов? Зохиолч үүгээр юу хэлэхийг хүссэн бэ? гэх мэт асуулт, даалгавраар чиглүүлж болно.

**Зохиолчийн зорилго ба хам сэдвийн уншигчид үзүүлэх үр нөлөөг үнэлэх**

**Энэ үйл ажиллагааг:**

- Чи өөрөө болон ангийнхан чинь юу гэж үзэж байна вэ?
- Судлаач, шүүмжлэгчид юу гэж үзэж байгааг уншиж, харьцуулаарай гэх мэтээр даалгавар өгч болно. Жишээ нь: Ш.Сүрэнжав “Тэнгэрийн хүү” шүлгийг судлаач Л.Хүрэлбаатар “Тэнгэрийн ариун хөвгүүн газрын баг идээнд ирж, “хиртэж”, “бэртэж” тэр ч атугай “Сэтгэлийнхээ рашаанаас найраг болгон нэрж хүмүүст амсуулсан. Нэг нь амтархан шимж байхад нөгөө нь аяглан тамшаалж байсан, аанай бас тургиж ч байсан, аль алинд нь ч би гомдоогүй” гэж тэнгэрийн жаргалыг газрын зовлонд мөргөлдүүлж, бясалган шүүмжлэх санааны хүчийг нэмэн ахиулах бүр тэнгэрийн хөвгүүн бус, газрын хөвгүүний дүр байдалд санаа хэлбэрэн шилжиж, нэрийдсэн үгсийн доогуур нууж орхисон жинхэнэ өгүүлэх утгын дэлбээ цомог нэг нэгээр задран нээгдэж байна. Энэ бол тэнгэрийн үүднээс газрыг бус, газрын үүднээс тэнгэрийг харж, тэнгэрийн хөвгүүнээр газрын хүнийг нээж, санаагаар чимж урнаар дүрсэлсэн бясалгалын ур болно”

С.Дашдооров “Бууж мордох хорвоо” өгүүллэгийн талаар зохиолч Г.Аюурзана “Үнэхээр сайхан өгүүллэг, жинхэнэ монгол философи шүү. Монголын утга зохиолд ийм бүтээл цөөхөн” гэсэн бол судлаач П.Батхуяг “Амьдрал- соёл гэдэг логикоор “түмэнд нүүрийн буянтай амьдрах” эрхэмнэл. Нэг талаас үнэт зүйл юм. Монгол хүн амьдралдаа ямар соёлыг эрхэмлэдэг вэ? Ямар үнэт зүйлийг эрхэмлэдэг вэ? гэсэн холбоо асуулт урган гараад түүнд нь зохиолч “НҮҮРИЙН БУЯНТАЙ АМЬДРАХ” гэсэн монгол философиор хариулт өгч байгаа юм. Өөр олон тайлбар хэрэггүй” гэх мэтээр олон олон уншигчид өөр өөрийн санааг дэвшүүлж илэрхийлсэн байдгийг сурагчид уншиж, судалж, харьцуулж, өөрийн санааг баримтжуулж, эсрэгцүүлж гаргана.

**12.16**

Зохиолын сэдэв, утга санаа, хам сэдвийн холбоо хамаарлаар далд утгыг тайлан тайлбарлах

Энэ суралцахуйн зорилтын хүрээнд сурагчид зохиолын сэдэв, утга санаа, хам сэдвийн холбоо хамаарлаар далд утгыг тайлан тайлбарлах чадварт суралцана. Үүнд:

1. Зохиолын сэдэв, утга санааг тодорхойлж, далд утгыг тайлбарлах
2. Хам сэдвийн далд утгыг тайлбарлах
3. Зохиолын дүр, орчин, нөхцөл байдал, үйл явдлыг судлах явцдаа далд утгыг судалж, тайлбарлах

Далд утгатай зохиолуудыг сонгоно. Хам сэдвийн цаана далд утга илэрдэг гэж үздэг тул нийгэм, соёл, түүх, шашин, улс төр, шинжлэх ухаан, намтрын хам сэдэв бүхий зохиол сонгоно.

**Багшийн анхаарах зүйл:**

Энэ зорилтын хүрээнд мөн гурван үйл ажиллагааг санал болгосон. Үйл ажиллагаа тус бүрд дараах арга зүйг зөвлөж байна.

**Зохиолын сэдэв, утга санааг тодорхойлж, далд утгыг тайлбарлах**

Энэ үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд өмнөх суралцахуйн зорилтын хүрээнд зохиолын сэдвийг тодорхойлсон байгаа тул утга санааг тайлбарлах нь сурагчдад хялбар дөхөм байх болно. Зохиолын санааг дүгнэлт хэсэгт хэрхэн дүрсэлсэн, эсвэл сурагчид эхийн утга санааг яаж олж харсантай холбох хэрэгтэй. Зарим тохиолдолд хэд хэдэн тайлбар хэсэг байж болох ба энэ тохиолдолд хамгийн сайн болон илүү их гол утга агуулсан, зохиолчоос уншигчдад хэлэхийг

хүссэн гол санаатай хэсэг рүү чиглэх хэрэгтэйг ойлгуулж, санаагаа нэгтгэх аргад сургах нь томоохон зохиол дээр ажиллахад туслах болно.

Зохиолд дэвшүүлсэн асуудал, утга санаа, өгүүлэмж бүрийг шинжлэхдээ:

- Эхний уншилтаар зохиогчийн дэвшүүлсэн асуудал, утга санааг таамаглаж, асуудал дэвшүүлэх
- Судалгаат уншилтаар зохиолын эхлэл, гол, төгсгөл хэсгийн санаа, тэдгээрийн дараалал, өрнөл, уялдаа холбоо гэх мэтийг тайлбарлаж, таамаглалаа батлах
- Үйл явдал, өгүүлэмжүүд нь сэдвийг дэмжиж, дүрсэлж буй эсэх, энэ нь дүгнэлтэд тусгагдаж буй эсэх гэх мэт.

Дээрх задлан шинжилснээ нэгтгэн дүгнэж, тайлбар болон үнэлгээ дүгнэлт хийхдээ задлан шинжилгээний үр дүнг зураглавал ойлгомжтой байдаг. Задлан шинжилгээ, нэгтгэн дүгнэлтийг үндэслэн зохиолын ач холбогдол, үнэ цэнийг тодорхойлох нь сэдэв, утга санааг гаргахад чухал юм. Зохиолыг үнэлэхдээ хэсэг бүрийн утга, санааг харалзана. Үнэлгээ хийхдээ:

- ✓ Зохиолын утгыг олж харахдаа тайлал хэсгийг ашигладаг.
- ✓ Зохиогчийн бүтээсэн санааны дараалал, уялдаа холбоог тодорхойлох шинжилгээ хийдэг.
- ✓ Зохиолд өгүүлэгдэж байгаа нөхцөл байдалд үнэлгээ өгч болно.

Мөн уншсан хэсгийнхээ гол, чухал санааг тодорхойлох өөр нэг арга нь:

- ✓ Хэрвээ нэгээс олон санаа дурдагдсан байгаа бол хамгийн чухал нь аль нь болохыг тодорхойлох
- ✓ Зохиогчийн утга санаа тодорхойлсон эхлэлийн цэгийг тодорхойлох.
- ✓ Зохиолын дүрүүдийн үзэл бодол, үйл хэргийг бие биеийнх нь уялдаа холбоонд авч үзээд, зохиолд тэднээр дамжуулан ямар утга санааг хэрхэн урласныг олох. Ингэхдээ туслах дүрүүдийн үзэл бодол, үйл хэрэг гол дүрдээ хэрхэн үйлчилж байгаа шугамаар нь хөөж олох хэрэгтэй.
- ✓ Зохиолд зохиолч илүү гүн гүнзгий утга санааг илэрхийлэхийн тулд ямар нэгэн бэлгэдлийг хэрэглэсэн эсэхийг шинжлэх. Энэ нь зохиолын утга агуулга болоод зохиомжид хэрхэн нөлөөлж байгааг тайлбарлах нь чухал. Бэлгэдэл бол бодит байдлаас илүү гүнзгий утга санааг илэрхийлдэг. Жишээ нь Б.Лхагвасүрэн “Тамгагүй төр” жүжигт ганц модыг ямар үүрэгтэй дүрслэв? Энэ нь зохиолд хэдэн удаа гарч байна вэ? Ганц модоор дамжуулж зохиолчийн хэлэх гэсэн далд санаа юу байв? гэх мэтээр эргэцүүлэх үйлд сурагчдыг хөтлөх хэрэгтэй. Зохиолд гарч байгаа орчин, нөхцөл байдал, сонгосон үг хэллэг нь бүгд л өөр өөрийн үүрэгтэй, тодорхой хэмжээнд далд утгатай байдаг тул сурагчдаар сайтар тайлбарлуулж сургавал хэн хүний хараагүй, хэлээгүй тийм өвөрмөц санааг олж харахыг хичээж, судалгаат уншлагад суралцах болно.

Хам сэдвийн далд утгыг тодорхойлох

Аливаа зохиол нь ил ба далд утгатай байдаг. Ялангуяа ахлах ангид судалж байгаа зохиолууд нь зохиолын өгүүлэмжээр шууд илэрдэггүй, нарийвчилсан судалгаа, тайлал тайлбар хийж сая ойлгогдохоор далд утгыг цаанаа давхар агуулж байдаг. Жишээ нь: С.Дашдооров “Бууж мордох хорвоо” өгүүллэгт “Ангаа өвгөн ингээд явчихдаг байж... Нутгийн нуруутай хэдэн өвгөний нэг байлаа даа...” гэж өгүүлснээ ийш тийш ямар нэг юм чимээ чагнаж бараа харж, сэлбэлзэн харснаа маанийн шад бувтнан уншив...” гэсэн хэсэгт зохиолч Төгөөг яагаад ямар нэгэн чимээ чагнаж байгаа мэтээр бичив? Яагаад харах үйлийг сэлбэлзэн гэдэг үгээр шинжийг тодотгож өгөө? гэж эргэцүүлж уншвал зохиолд ямар цаг үеийн амьдрал дүрслэгдсэн, тэр үед хүмүүсийн шүтэх эрх хэр хязгаарлагдмал байсныг олж тайлбарлах гэх мэт.

С.Дашдооров “Бууж мордох хорвоо” өгүүллэгт “Өгүүллэгийн бэлгэдэл бүхий зохиомжит хэсэгт “...гарт өртсөн жижиг сажиг чулуу хэд гурваар нь түүн нойтон алган дотроо өнхрүүлэн эрх мэт нэг нэгээр нь имрэн сэлгэсэнээ ганц ганцаар нь эрхий хурууныхаа хумсан дээр гарган нясалж саатав.” /С.Дашдооров. “Бууж мордох хорвоо” 2012/ гэсэн нь Төгөөгийн сэтгэлд өрнөж буй хямралыг ЧУЛУУГААР тэмдэгжүүлжээ. Нэг үгээр жижиг чулуунууд Төгөөгийн тархин доторх бодлууд юм. Бодлуудаа нэг нэгээр нь нясалж гүн санаашралд автаад байгааг харуулжээ” гэж П.Батхуяг судлаач далд утгыг дүгнэснийг өөрсдийн тайлбараар баталж, эсвэл эсрэгцүүлж ч болно. Мөн зохиол бүтээлд байгаа хэвшмэл болон өвөрмөц хэлцүүд нь ямар санааг товч илэрхийлэв?, ямар дүрслэл болов?, утгыг нэмэн дэлгэрүүлбэл ямар санаа цаана нь байгаа зэргийг тайлбарлах шаардлагатай. Жишээ нь:



“Тунгалаг Тамир” романыг зохиолч “Хорвоо чи хүний зовлонд цадах болоогүй юу?” гэж яагаад төгсгөв гэх мэтээр сурагчид илүү далд утгын нарийвчлал хийж болох юм.

“Олон номыг нэг удаа уншсанаас нэг номыг олон дахин унших нь хамгийн үр дүнтэй... Дахин дахин унших гэдэг бол унших үйлийн дээд нь” гэж төрийн шагналт зохиолч Д.Батбаяр “Бүтээхүйн зүй тогтол Сайхныг бүтээх нууц” (УБ., 2007, 85 дугаар тал) хэлсэн байдаг. Урлаг, уран зохиолын бүтээл туурвил бол уран бүтээлчийн дотоод ертөнцийн үр жимс. Хэдий чинээ л арвин, цараа хүрээ их оюунлаг дотоод ертөнц байна вэ? тэнд бүтэж бүрэлдсэн бүтээл туурвил төдий чинээ ухаалаг, гүн гүнзгий, зохис төгөлдөр байдаг учир тэр зохис төгөлдрийг олж нээх ухааны нүдтэй болох нь чухал юм.

Шүлгийн айзам хэмнэл болон адилтгал, ёгтлол, егөөдлийг нарийвчлан шинжилж, далд утгыг тайлбарлаж сурна. Мөн энэхүү туршлага дээрээ үндэслэн зохиолч энэ шүлгээрээ ямар асуудлыг дэвшүүлсэн хийгээд энэхүү асуудлын хүрээнд ямар хам сэдвийг хөндөж, зохиолчийн нийгэмд хандах хандлага хэрхэн илэрч байгааг судлан, шүлэгт үгээр бичсэн утга санаа болон үгээр илэрхийлэгдээгүй далд санааг холбон ойлгож сурна.

Зохиол бодит хийгээд хийсвэр ертөнцийн тусгал байдаг тул зохиолд ямар нэг орчин түүний дотоод хэсэг бүлгүүд далд утга илэрхийлж, өөр өөрийн үүрэгтэйгээр дүрслэгдсэн байдгийг сурагчдад зөв ойлгуулах хэрэгтэй. Жишээ нь: Дүрийн нийгмийн орчин амьдралтай нь уялдуулан өвөрмөц хэлбэртэй дүрсэлснийг тайлбарлан ярих.

Нийгэм ахуйн таатай ба таагүй байдал хэрхэн дүрслэгдэж байгааг илрүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх. Яруу найрагт уянгын баатрын сэтгэл санааны байдлыг орчин ахуй, байгалийн байдалтай уялдуулан дам дашрамд бэлгэдэх, уянгын эерэг сөрөг өнгө аяс, сэтгэлийн байдлыг нээхэд яаж ашиглаж, ямар үүрэгтэй байгааг илрүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх.

<p><b>12.1в</b> Зохиолын өгүүлэгдэхүүн, зохиомжийн нэгжүүдийг ялгаж, утга санаанд хэрхэн нөлөөлж буйг дүгнэх</p>	<ol style="list-style-type: none"> <li>1. Хүүрнэл, байгалийн зураглал, зүүд, харилцан яриа, дотоод яриа, үглэл яриа, зохиолчийн тэмдэглэл, эргэцүүлэмж, дурсамж, өчил, хөрөг гэх мэт зохиомжийн нэгжүүдээс уншсан зохиолд хэрэглэсэн эсэхийг ялган тэмдэглэх</li> <li>2. Туульсын зохиолд зохиомжийн нэгжийг зохиолч ямар зорилгоор сонгон бичсэнийг ярилцах Жишээ нь, хэрвээ байгалийн зураглал байхгүй бол орчин нь ямар байх бол? үйл явдлаа өрнүүлэхдээ байгалийн зураглалыг ямар зорилгоор бичсэн бол? ямар дүрийн ямар төрх байдал тодрохгүй байх бол? гэх мэтээр эргэцүүлэн унших</li> <li>3. Уянгын шүлэгт хэм хэмнэл, аялгуу, дүрслэлийн уран илэрхийлэл нь уянгын шүлэг дэх зохиомжийг үүргийг гүйцэтгэдэг гэдгийг батлах</li> <li>4. Шүлгийн уран нарийн дүрслэлүүд нь шүлгүүдийн утгыг илэрхийлж байгааг ярилцах</li> <li>5. Утга санаанд хэрхэн нөлөөлж байгааг дүгнэхдээ: “Аянгат цагийн тууж”-д хэлмэгдэж явсан түүхээ ярихад “дурсамжийн” зохиомж нь их оновчтой юм. Гол баатар нь амьдралынхаа гэрэл гэгээтэй, аз жаргалтай үеэ ярихад нар гарч, цэлмэг тэнгэртэй болоход хэлмэгдэж явсан хэцүү цаг үеэ ярих болоход үүл хурж, цахилгаан цахидаг гэж бичсэнээс зохиолч байгалийн зураглалыг дүрийнхээ сэтгэл зүйг тодруулахад ашиглажээ гэж дүгнэж болно” гэх мэтээр задлан шинжлэн, нэгтгэн дүгнэн ярина.</li> </ol>	<p>Хүүрнэл, байгалийн зураглал, зүүд, харилцан яриа, дотоод яриа, үглэл яриа, зохиолчийн тэмдэглэл, эргэцүүлэмж, дурсамж, өчил, хөрөг зэрэг зохиомжийг хэрэглэн уран сайхнаа бүрдүүлсэн эх зохиол</p>
--	--	---

**Багшийн анхаарах зүйл:**

Дүгнэх гэдэг танин мэдэхүйн дээд үйлийн чадварыг эзэмшсэнийг хөгжүүлэх нь энэхүү суралцахуйн зорилтын онцлог юм. Сайн задлан шинжилж уншиж, ярьж, бичиж сурсан сурагч дүгнэж чаддаг. Өөрөөр хэлбэл дүгнэхийн тулд эхлээд сайн задлан шинжлэх хэрэгтэй.

Энэ зорилтоос багш зохиомжийн тухай онолын ойлголтыг мэддэг байх учиртай. Өгүүлэгдэхүүнтэй андуурах тохиолдол утга зохиолд судлалд байдаг. Өгүүлэгдэхүүн гэдэг нь эхлэл, зангилаа, өрнөл, туйл, тайлал гэсэн бүрдүүлбэртэй бол зохиомж нь “хүүрнэл,

байгалийн зураглал, зүүд, харилцан яриа, дотоод яриа, үглэл яриа, зохиолчийн тэмдэглэл, эргэцүүлэмж, дурсамж, өчил, хөрөг” зэрэг бүрдүүлбэртэй. Үнэлгээний дараах асуултыг хэрэглэж болно. “Үер” зохиолын жишээн дээр:

1. Зохиолч хүний сайхан сэтгэлийг магтан дуулахдаа ямар зохиомжийг сонгож хэрэглэсэн бэ? Яагаад?
2. Хэрвээ баатруудын хоорондох харилцан яриа байхгүй бол ямар утга санаа алдагдах бол? Харилцан яриа нь ямар үүрэгтэй байна вэ?
3. Дурсамж хэсгийг зохиолын гол хэсэгт зохиомжилж өгсөн нь ямар утга санааг илэрхийлэх гэсэн бэ? гэх мэт

Зохиомж

Латин хэлний /compositio/"бүрэлдэхүүн, нэгдэл" гэсэн үгээс гаралтай нэр томъёо

Зохиомжийн бүрэлдүүлбэрүүд

<p><b>Хүүрнэл /анг-narration, орос-повествование/</b> Зохиолч өөрөө, эсвэл хөндлөнгийн өгүүлэгчийн хэл яриагаар зохиолын үйл хөдөлгөөний дэс дарааг гаргахыг хэлнэ. Ихэвчлэн үргэлжилсэн ба уянга туульсын төрөлд хэрэглэгдэнэ. Жишээ нь: Ж.Лхагва "Эвэр", Д.Намдаг "Үрэгдсэнийг хүлээгч"</p>	<p><b>Харилцан яриа /гр-didacticos-хөөрөлдөх, диалог/</b> Хоёр ба түүнээс дээш баатруудын хоорондын яриагаар тэдний зан төрх, амьдралын нөхцөл байдлыг илрүүлэн гаргасныг хэлнэ. Үргэлжилсэн үгийн зохиолд өргөн хэрэглэгдэхийн зэрэгцээ, жүжгийн зохиолд дүрслэлийн гол арга болно.</p>
<p><b>Тодорхойлол /гр-character-онцлог, шинж/</b> Баатрын зан төрх, онцлог шинжийг өөрийнх нь үгээр илэрхийлэн гаргасныг тодорхойлол гэнэ. Жишээ нь: Л.Ванганы "Жож Сэрээнэн" өгүүллэгт "За, би ч ямаа, монгол үхэр хоёрт яснаасаа дургүй хүн дээ. Нутаг байдал нь таарах байна. Хуц л авах уу даа" гэж түүний ганцаардмал болохыг өөрийнх нь үгээр илэрхийлсэн</p>	<p><b>Зохиолчийн тэмдэглэл /фр-remarque/</b> Хэрэг явдлыг тодруулах, тайлбар хийх, баатрын зан төрх, онцлог шинжийг нэмэн тодруулж тайлбарлах үүднээс зохиолын тодорхой хэсэгт хийх нэмэлт бичвэр юм.</p>
<p><b>Үглэл яриа /гр-monoslogos-нэг, ганц, монолог/</b> Дүрийг тодотгож байдаг, ямар нэгэн хариу шаардахгүйгээр өөртөө юм уу бусдад хандан хэлсэн, нэг талын ганцаарчилсан яриа. Жишээ нь: "Тунгалаг тамир" романд Ням гэж хэн болохыг өөрийнх нь үглэлээр тодорхой гаргажээ.</p>	<p><b>Хөрөг дүр /фр-portrait-дүрс, зураг/</b> Энэ нь зохиолын баатрын зүс царай, хэлбэр галбир намба төрх, хувцас хунар, үйл хөдөлгөөн, өвөрмөц араншин, сэтгэл санааны байдал зэргийг зураглан гаргах явдал юм. Жишээ нь: П.Пүрэвсүрэнгийн "Өшөө" өгүүллэгт Доригийн хөрөг дүрийг "Гэгээ таттал яралзсан том цагаан шүдтэй, өтгөн хар хөмсөг зөвхийг нь дарснаас болсон мэт хийхгэр хурц нүдтэй, хулмайсан хоёр чих нь ар тийшээ наалдсан юм шиг, хар хүрэн нүүртэй зузаан эр" гэхчлэн дүрсэлжээ.</p>
<p><b>Өдрийн тэмдэглэл /анг-diary/</b> Тодорхой хэсэг хугацаанаас эхлэн хэдэн жил, бүр бүх насаараа тэмдэглэл хөтөлсөн бичмэл түүхийг өдрийн тэмдэглэл гэнэ. Энэ нь зохиолчийн өв, уран бүтээлийн нэг хэсэг, мөн хувийн нууц архив юм.</p>	<p><b>Байгалийн зураглал /фр-paysage-газар нутаг/</b> Зохиолд байгалийн байдлыг урнаар дүрслэн бичхийг байгалийн зураглал гэнэ. Байгалийн зураглал нь үйл явдал болж байгаа газар орон, цаг улирлыг харуулах, баатрын сэтгэл санааг нээн харуулахад тус нэмэр болдог.</p>
<p><b>Өчиг /анг-testimony, орос-внутренний монолог/</b> Сэтгэлийн өчиг нь үглэл ярианы нэг хэлбэр юм. Гадагшаа илэрдэггүй, баатрын сэтгэлийн дотоодод болдог яриа юм. Жишээ нь: "Хувьсгал танаа өчье" роман дахь М.Дугаржавын дотоод сэтгэлийн өчгүүд</p>	<p><b>Зүгд /анг-dream/</b> Зохиолын баатар юм уу өгүүлэгчийн зүүдээр өнгөрсөн, ирээдүйд болох</p>
<p><b>Захидал /анг-private, орос-письмо/</b> Баатрын зан төрх, сэтгэл санааны хоорондын харилцааг илэрхийлэх, үйл явдлыг</p>	

<p>холбох зорилгоор хэрэглэдэг зохиомжийн бүрдэл хэсэг. Жишээ нь: Д.Пүрэвдорж "Сэгс цагаан богд", Ц.Дамдинсүрэн "Буурал ижий минь" зэрэг найраглалууд</p>	<p>зүйлүүдийг болж байгаа мэтээр бичих аргыг хэлнэ. Жишээ нь: Дулаан Хайрханы хүүгийн зүүд /Д.Намдаг "Хөгшин чоно ульсан нь"/, Б.Ринчен "Мангаа Доогийн эцсийн зүүд"</p>	
<p><b>Уянгын халил /анг-lyrical/</b> Зохиолын агуулгыг бүрдүүлэн нээх, үйл явдлын эрчимжилт, шийдлийн эгзэгтэй үе шатанд зохиолч зохиолынхоо шугамаас ямар нэгэн хэмжээгээр хазайж, өөр өгүүлэмж рүү хальтран орох, хувийн үнэлэлт, эргэцүүлэмж рүү шилжсэнээс үүсэн бий болдог үйл явдлын бүрдэл хэсэг юм. Жишээ нь: Хорвоо чи хүний зовлонд цадах болоогүй юу? /Ч.Лодойдамба "Тунгалаг тамир"/</p>	<p><b>Оруулбар /анг-insertion/</b> Зохиолын явдлын системд шууд хамааралтай биш боловч уг хэрэг явдлын утга санааг нэмэн дэлгэрүүлэхэд тодотгоол хийсэн шинжтэй тусгай хэсэг юм. Жишээ нь: Б.Ринчений "Үүрийн туяа" романд түүх, домог, болсон явдал, угсаатны зүйн шинжтэй оруулбарууд их бий.</p>	
<p>➤ Зохиомж бол агуулгат хэлбэр. Өөрөөр хэлбэл зохиолын хэлбэрийн талын ойлголт буюу уг зохиол хэр уран санаагаар илэрч байна вэ гэдгийг тодруулдаг зүйл юм. ➤ Уран зохиолын төрөл зүйл бүрд их өвөрмөц байдлаар илэрдэг.</p>		
<p><b>12.1г.</b> Зохиолын дүрийн хэв шинжийг тодорхойлж, утга санаанд хэрхэн нөлөөлж буйг тайлбарлах</p>	<ol style="list-style-type: none"> <li>1. Сонгосон эх зохиолын утгыг ойлгож унших, уншсанаа ярилцах, бие биедээ асуулт тавих</li> <li>2. Дүрийн хэв шинж гэдэг ойлголтын тухай ярилцах, таамаглах</li> <li>3. Дүрийн хэв шинжийг тодорхойлохын тулд: <ul style="list-style-type: none"> <li>- Сонгосон дүрийн нийтлэг зан төрхийг ярилцах, тухайн үеийн нийгмийн хүн зонд, хувь хүнд байдаг нийтлэг ямар зан чанар, онцлог байгааг эргэцүүлэн тунгаан бодох, зохиолоос жишээ татах</li> <li>- Дараа нь сонгосон дүрийнхээ хувь хүний өвөрмөц онцлог шинжийг тодруулж ярилцах, зохиолыг дахин унших</li> </ul> </li> <li>4. Зохиолчийн бүрдүүлсэн дүрийн хэв шинж нь зохиолын утга санаанд хэрхэн нөлөөлж байгааг судлах Судлахдаа дараах асуултыг хэрэглэх <ul style="list-style-type: none"> <li>- Дүрийн нийтлэг шинжид нийгмийн ямар асуудлыг гаргасан бэ? Нийгмийн байдлаас шалтгаалсан дүрийн зан төрх, ажил үйлсийн онцлог юу байна вэ? Ингэж бүтээсэн дүрээрээ дамжуулж зохиолч ямар утга санааг уншигчдад хэлэхийг хүссэн бол?</li> <li>- Нийтлэг шинжтэй бүтээсэн дүрийн хувийн онцлог юу байна вэ? Үүгээрээ зохиолч зохиолынхоо ямар утгыг дэлгэрүүлсэн бэ?</li> <li>- Бүтээсэн хэв шинжит дүрээрээ дамжуулж, нийгэмд, хувь хүнд юуг хэлэхийг хүссэн бэ? Ямар дүрээс ямар үлгэр дуурайл авах, ямар дүрийг жигшихийг зохиолч зорьсон бэ?</li> </ul> </li> </ol>	<p>Ч.Лодойдамба "Тунгалаг Тамир" роман.</p> <p>Дүрийн өсөлт, бууралтыг үзүүлсэн, нийгмийн цаг үеэс шалтгаалж, дүрийн зан төрх нь бүрэлдсэн зохиолыг сонгон уншина.</p>
<p><b>Багшийн анхаарах зүйл:</b> Энэхүү суралцахуйн зорилтыг хэрэгжүүлэхийн тулд багш "дүрийн хэв шинж" гэсэн онолын ойлголтыг мэддэг байх хэрэгтэй. Монголын уран зохиолд судлаачид Тунгалаг Тамир романы Итгэлтийн дүрийг хэв шинжит дүр гэж үздэг. Учир нь түүний дүрийг нэг талаас харахаар 1921 оны хувьсгалын жилүүдийн матай хөрөнгөтэй хүмүүсийн нийтлэг талууд их байдаг. Тухайлбал, мал хөрөнгөтэй, зарцтай, бусад язгууртны адил гэр орон, гэр бүл, ихэрхэг зан байх атлаа бусдаас ялгарах хувь хүний онцлог шинж нь илүү тод байдаг. Үүнийг түүний хүмүүсийг хөгжөөж дэмжих замаар хамаг ажлаа хийлгэдэг сүйхээтэй зан, 10-г олохгүй юманд 1-ийг гаргахгүй байх бодол, хөрөнгө харж охиноо айлд өгөхгүй байгаа зэрэг олон үйлдлээс</p>		

харж болно. Хэв шинж гэдэг нь нийтлэг зан чанарын дээд хэлбэр юм. Нийтлэг зан чанарыг ярилцсаны дараа тухайн хувь хүний онцлогийг тодруулан тодорхойлох учиртай. Жишээ нь, энэ цаг үед ажиллаж байгаа Наран гэдэг багшийн дүрийн хэв шинжийг тодорхойл гэвэл 1. Нийтлэг зан төрхийг нийгмийн онцлогтой холбон ярих хэрэгтэй. 2. Хувь хүний онцлог талыг тодруулах хэрэгтэй. Өнөө цагийн багшийн нийтлэг зүйл нь бүгд их дээд сургууль төгссөн, бүгд ачаалалтай, цаасанд дарагдаж ажилладаг, ихэнх нь цалингийн зээлтэй гэх мэт. Наранд ийм нийтлэг тал байгаа ч бусдаас өөр зан занартай, хүүхэд бүрийг хүндэлж харьцдаг Үүндэлж харьцдаг гэдэг нь нийтлэг шинж гэж андуурч болохгүй\ тал нь түүний хэв шинжийг бүрдүүлж байгаа хэрэг юм.

Сурагч эх зохиол уншаад сонгосон дүрийнхээ нийтлэг талыг нийгмийн онцлог байдалтай холбон олж харж, дүрийнхээ хувийн онцлог шинжтэй нь хэв шинжийн тухай ярьж байвал сайн суралцсанд тооцно. Мөн дүрийн хэв шинж нь зохиолын утга санаатай хэрхэн холбогдож байгааг асуултын тусламжтайгаар задлан шинжилж, эрэл хайгуул хийж, хүүхэд бүр өөр өөрийнхөөрөө ТАЙЛБАРЛАЖ, ХЭЛЭЛЦЭЖ байвал хичээлийг үр дүнтэй болж байна гэж үзэж болно.

<p><b>12.1д.</b> Зохиолын гадаад ба дотоод орчин нь дүрийг тодруулахад хэрхэн нөлөөлж буйг задлан шинжлэх</p>	<p><b>Зохиолын гадаад орчныг шинжлэх</b></p> <ol style="list-style-type: none"> <li>1. Зохиолд сонгон үзүүлсэн орчин, нөхцөл байдлыг тодруулах</li> <li>2. Зохиолч ямар зорилгоор ийм орчин, нөхцөл байдлыг гаргасныг тайлбарлах</li> <li>3. Зохиолын үйл явдлын өрнөлд нөлөөлж буй нөхцөл байдлыг тодорхойлж, ямар үүрэгтэй орсныг үнэлэх</li> <li>4. Зохиолд дахь орон цаг нь тухайн цаг үеийн нийгэм, түүхийн хам нөхцөлтэй нь хэрхэн холбогдож байгааг тайлбарлах</li> <li>5. Үзүүлсэн орон нь бодитой, тодорхой газар орон эсвэл ерөнхий газар орон байгаа эсэхийг тодорхойлох</li> <li>6. Зохиолд үзүүлж буй цаг нь бодитой, тодорхой түүхэн цаг уу, эсвэл ерөнхий эрт нэгэн цаг байгаа эсэхийг тодорхойлох</li> <li>7. Зохиолуудад үзүүлж буй хэрэг явдлуудын орон цагийг тодруулах</li> <li>8. Зохиолын өгүүлэгдэхүүний аль хэсэгт орчны өвөрмөц, содон дүрслэл гарч байгаа хийгээд ингэж үзэж байгаа шалтгаанаа тайлбарлах</li> <li>9. Зохиолуудын нийгэм, түүх, соёлын хам сэдвийг тодорхойлох ямар орчин, нөхцөл байдал байгааг үнэлэх</li> <li>10. Зохиол дахь ямар орчин, нөхцөл байдал хамгийн содон байсан гэдгийг сонгож яагаад гэдгээ баримтад тулгуурлан тайлан тайлбарлах</li> <li>11. Зохиолуудын орчныг харьцуулж, дүгнэлт гаргах</li> <li>12. Орчны дүрслэлд ямар нэг эд зүйл, юмс багтсаныг баримтаар нотлуулах гэх мэтийн үйл ажиллагаанд хөтөлж болно.</li> </ol> <p><b>Зохиолын гадаад орчин нь дүрийг тодруулахад хэрхэн нөлөөлж байгааг тодорхойлох</b></p> <ol style="list-style-type: none"> <li>1. Байгаль, цаг уурын байдал нь дүрийн сэтгэл зүйд нөлөөлж байгааг баримтаар нотолж дүгнэх.</li> <li>2. Зохиол дахь нөхцөл байдлын онцлог нь дүрийн давуу ба сул талыг илэрхийлж байгааг үнэлэх</li> <li>3. Орчны өөрчлөлтөөс дүрийн бодол санаа, үйлдэл, үзэл бодол өөрчлөгдөж байгаад дүгнэлт хийх.</li> <li>4. Хэрэг явдлуудад хэн хэн хэрхэн оролцож байгааг анхаарч унших</li> </ol>	<p>Орон цагийн орчны дүрслэл, дүрүүдийн хоорондох харилцааны таатай ба таагүй уур амьсгалыг тодруулан дүрсэлсэн үргэлжилсэн үгийн болон жүжгийн сонгодог зохиолыг сонгон уншина.</p>
---	--	--

	<p>5. Зохиол дахь хэрэг явдлын зөрчил нь дотоод орчныг гаргахад ямар үүрэгтэй байгааг тайлбарлах</p> <p>6. Зохиолын баялаг дүрслэлийг мэдэрч, төрөл зүйлийн ялгарах онцлогийг гаргах</p> <p>7. Эмгэнэлт жүжгийн дүр нь /Арчуг/ дээд хүчний оролцоо, зан суртахууны албадлага, хүсэл шуналын эрхшээлт байдал зэргийн алинд нь илүү автаж байгааг баримтаар нотлуулах</p> <p>8. Өгүүллэгт гол дүрийн амьдралд тохиолдсон нэгэн дан хэрэг явдлыг үзүүлдэг болохыг баримтаар нотлуулах</p> <p>9. Зохиолуудын утга санаа, орчин, дүр, бэлгэдэлт чанарыг харьцуулж жиших</p> <p>10. Орчны дүрслэлд багтаасан ямар нэг эд зүйл, юмс нь орчныг тодруулахад нөлөөлж байгаа үнэлэх</p> <p>11. Нөхцөл байдал нь дүрийн зан төрхтэй эсрэгцэж байгаа болон нэгдэж байгааг тодруулах</p> <p><b>Зохиолын дотоод орчин дүрийг тодруулахад нөлөөлж байгааг шинжлэх: /Жүжиг роман, өгүүллэг/</b></p> <p>1. Дүрийг ямар нөхцөл байдлын дунд үзүүлснийг тайлбарлах</p> <p>2. Дүрүүдийн хоорондох сэтгэл зүйн уур амьсгалыг тодруулан унших, зохиолын аль хэсэгт тод ялгарч байгааг тэмдэглэх</p> <p>3. Ээдрээтэй, зөрчил тэмцэлтэй орчин болоод дүрийн зан төрхийн хамаарлыг баримтаар нотлох</p> <p>4. Гол баатрын дүрийн өсөлтийг дүрийн сэтгэл зүйтэй холбож тайлбарлах</p> <p>5. Зохиол дахь нөхцөл байдлын онцлог нь дүрийн давуу ба сул талыг илэрхийлж чадаж байгаа эсэхэд дүгнэлт өгөх</p> <p>6. Орчны болоод цаг хугацааны хоёр өөр нөхцөлд дүрийн зан төрхийн өөрчлөлт хэрхэн илэрч байгааг жишиж харьцуулах</p> <p>7. Гол дүрийн дотоод бодол, сэтгэл зүйн өнгө аяс нь \ гунихрал, санаашрал, цөхрөл, шийдэмгий байдал\ нь бусад дүрийг тодруулахад хэрхэн нөлөөлж байгааг зохиолоос эш татаж тайлбарлах</p> <p>8. Дүрүүдийн бодлоос улбаалсан эерэг үйлдлүүдийг тоочиж тайлбарлах</p> <p>9. Дүрүүдийн төсөөлөл хийгээд бодит байдлын ялгаа нь дүрүүдийг ямар хэрэг явдалд татан оруулж байгааг тайлан тайлбарлах</p> <p>10. Зохиолын гадаад ба дотоод орчин нь дүрүүдийг шууд ба шууд бусаар тодорхойлж байгааг зохиолоос эш татаж тайлбарлах</p> <p>11. Дүрийн сэтгэл зүйн байдлаар илэрч буй зан төрхийн өвөрмөц чанар амьдралын утга учрыг нээхэд нөлөөлж байгааг тайлан тайлбарлах</p> <p>12. Дүрүүдийн зан төрхийг тодруулахад зохиолын орчин нөхцөл маш их нөлөөлж байна уу, эсвэл хамаарч байна уу, тодорхой нөлөө үзүүлэхгүй байна уу гэдгийг баримтаар нотолж дүгнэх</p>	
--	---	--

**Багшийн анхаарах зүйл:**

*Тухайн зохиолыг уншихдаа зохиол бол бидний амьдралтай зэрэгцээ шугаманд оршиж буй бас л нэг амьдрал гэдгийг мэдэрч ойлгох хэрэгтэй.*

Зохиолын гадаад ба дотоод орчин нь дүрийг тодруулахад хэрхэн нөлөөлж байгааг тодорхойлох суралцахуйн зорилтыг хэрэгжүүлэхдээ эхлээд гадаад дотоод орчныг шинжилж,, дараа нь дүрийг тодруулахад нөлөөлж байгаа нөлөөллийг тодруулах үйл ажиллагаанд хөтлөх нь зүйтэй.

- Зохиолын орчин нөхцөл байдлын тухай тайлбарлахдаа уран зохиолын төрөл зүйлийн онцлогийг анхаарах нь зүйтэй. Үлгэрлэвэл: Өгүүллэг, тууж, роман нь туульсын зохиолын бүрэлдэхүүнд багтдаг бөгөөд **хэмжээ, дүрийн систем, хэрэг явдлын хамрах хүрээ** /гол дүрийн амьдралын нэг үе, эсвэл амьдралын олон хэрэг явдал/, **бүтэц зохиомж** / роман үйл явдлын олон шугамтай / **цаг хугацааг хамрах онцлог** / үйл хэрэг, хэрэг явдал нь явцуу хүрээнд байна уу, өргөн цар хүрээтэй байна уу/ гэх мэтийн зүйлээрээ ялгардаг. Өгүүллэг нь дүрийн / баатрын/ амьдралын нэгэн үе агшин, учрал тохиоллыг үзүүлдэг бол тууж нь гол дүрийн амьдралын аль нэг талыг сонгож, харьцангуй чөлөөтэй үзүүлдэг юм. <sup>1</sup>

Үйл явдлын олон шугамтай романы хувьд орчин нөхцөл байдлын дүрийн зан төрхийг тодруулахад нөлөөлж байгааг тайлбарлах нь нэлээд төвөгтэй.

Тууж, роман, жүжгийн хувьд дүрийг ямар нөхцөл байдлын дунд үзүүлснийг тайлбарлах нь нэлээд өргөн цар хүрээтэй байна. Жүжгийн зохиолд үзэгдэл бүхэнд тодорхой нэг хэрэг явдлын тухай үзүүлдэг учраас орон цаг ч бас түүнээ дагаад хувирч болох талтай. Жүжгийн зохиолын тайзны засал, эдэлж хэрэглэж байгаа эд зүйлсийн байрлал зэрэг нь зохиолын орчныг тодотгох тул уншуулахдаа дараах асуултыг хэрэглээрэй.

1. Зохиолч яагаад тайзаа ...ийнхүү бичсэн юм бол? Ямар дүрийн ямар зан чанарыг, хүсэл тэмүүллийг, зорилгыг үзүүлэхийг зорьсон бэ? Тайзны засал нь тухайн дүрийн зан төрх, гадаад дотоод шинжийг гаргахад оновчтой байна уу?
2. Эд хэрэглэлийн байрлалыг юу гэж бодож уншсан бэ? Дүрийн алхаа гишгээ, хөдөлгөөн, харц, дохио зангааг илэрхийлэхдээ ямар эд хогшлыг зохиолч сонгов? Яагаад ингэж сонгосныг ярилцаарай.

Жишээ нь, С.Эрдэнийн “Өвгөн шувуу” өгүүллэгт “Өвгөн шувуу” дуу, буурал азаргыг дүрсэлсэн байдаг. Өвгөдийн зан төрхийн онцлог, Жав өвгөний сэтгэлийн тамырыг тодруулахад бүр цаашилбал хүний амьдралын жам ёсны тухай философи ойлголтыг лавшруулахад дээрх хоёр зүйл нэлээд үүрэг гүйцэтгэж байна.

- Орчны дүрслэлд оруулж дүрсэлсэн эд зүйл, юмс нь бэлгэдлийн утгыг тайлан тайлбарлахад дөхөм болно. Өгүүллэгийн утга санаа, орчин, дүр, бэлгэдэлт чанарыг харьцуулж, дүгнэх даалгавар өгөөрэй. Үүнээс онцолж бэлгэдэлт чанарыг зохиолоос олуулж тайлбарлуулах талаар арга зүйн хувьд юу хийлгэж болохыг гаргаж харуулъя. Зохиолын нэрээс бэлгэдэлт чанарыг төсөөлүүлэн тайлбарлуулж болно. “Бууж мордох хорвоо”, “Өвгөн шувуу”, “Цагаан сар ба хар нулимс” зохиолуудын нэрээс нь далд утга, бэлгэдэл илэрч, гарч байна. Тухайлбал: Үхэх төрөх буюу хүний жам ёсны үзэгдлийг малчин хүний мориноосоо буух суух үйлээр төлөөлүүлж / Бууж мордох хорвоо/, хүний амьдрал жаргал зовлонгоор дүүрэн гэдгийг өнгөний харшууллаар харуулж, /Цагаан сар ба хар нулимс/, орчлон дэлхий, хүний амьдрал нь өөрийн зүй тогтол, учир шалтгааны дагуу хувиран өөрчлөгддөг зүй тогтолтой гэсэн санаа бүхий уртын дуу “Өвгөн шувуу”-ны агуулгатай холбож /Өвгөн шувуу/ гэж тус тус нэрлэжээ.
- Зохиолын дотоод орчны дүрийг тодруулахад нөлөөлж байгаа нөлөөллийг тайлбарлахад дүрүүдийн төсөөлөл хийгээд бодит байдлын ялгаа тэднийг ямар хэрэг явдалд татан оруулж байгааг тайлбарлуулах алхамчилсан даалгавар өгч болно. “Бууж мордох хорвоо” өгүүллэгийн Төгөө адуу хонь хоёроо Хангай өвгөнийг нутаглуулах замыг тосож бэлчээрлүүлсэн боловч маргааш нь нөхцөл байдал өөрчлөгдсөнийг хараад бухимдаж байгаа, “Тамгагүй төр” жүжигт өөрийн мах цусны тасархай болсон нуган үр Ачир \Их хатнаас төрсөн Эгээрэгийн нууц хүү\ - ыг хаан ширээнд залахыг мөрөөсөвч ухаан мөхөс, уужуу сэтгэлгүй байдал нь Арчугийн шийдвэрийг өөрчилж, уншигч, үзэгчдийн төсөөлснөөс огт өөр үйлдэл хийлгэхэд хүргэж

<sup>1</sup> Галбаатар .Д. “Уран зохиол: онол, түүх, шүүмжлэл”.УБ. 2012 он. 359 дүгээр тал

байгааг баримтаар нотлуулах нь зөв юм. “Тамгагүй төр” жүжгийн дүр нь /Арчуг/ дээд хүчний оролцоо, зан суртахууны албадлага, хүсэл шуналын эрхшээлт байдал зэргийн алинд нь илүү автаж байгааг баримтаар нотлуулахад дээр даалгавар нэлээд үүрэгтэй.

- Байгаль, цаг уурын байдал нь дүрийн сэтгэл зүйд нөлөөлж байгааг баримтаар нотолж, дүгнэх даалгавар дээр ажиллуулахдаа суралцагчаар ямар ч дүрслэл, хэрэг явдлыг жишээ татуулж болно. Түүнээ тайлан тайлбарлаж чадах нь л чухал. Бидний зүгээс ганц энэ л туйлын зөв гэж үзээд үнэлгээний шалгуураа боловсруулах нь учир дутагдалтай. “Өвгөн шувуу” өгүүллэг дэх “Жаран хэдэн жил амьдарсан хорвоо ертөнц зуныхаа нэг сайхан өдрөөр түүнийг үдэн гаргаж байна уу? Наран хэвийж, аг гангын үнэр анхилмал зөөлөн бөгөөд бүлээн сэвшээ үхлийн өмнө зоригтой тайван бай гэж илбэж байх шиг. Нутгийн хөх ногоон гүвээ толгод униар дунд замхран үзэгдэх нь уужим боловч ... “ дүрслэл ч дээрх даалгаврын хариултын нэг хувилбар байхыг үгүйсгэх аргагүй.

**12.1ж.**

Зохиолын хэл найруулга, уран дүрслэл, яруу хэрэглүүр, бичил дүрслэлийн уншигчдад үзүүлэх нөлөөг дүгнэх үнэлэх

1. Мэдэхгүй үг хэллэгээ хам сэдвийн хүрээнд тольчлон тайлбарлах
2. Тухайн зохиолыг уншаад өөрт таалагдсан, сэтгэлд нийцсэн үг хэллэг, уран дүрслэл, яруу хэрэглүүр, бичил дүрслэл бүхий үг хэллэг, өгүүлбэрийг ялгах, түүвэрлэх
3. Ялгаж түүвэрлэсэн яруу хэрэглүүр, уран дүрслэл, бичил дүрслэл нь дүр \орчин, утга\ -ийг тодруулахад хэрхэн нөлөөлж байгааг тайлан тайлбарлах
4. Ялгаж түүвэрлэсэн үг хэллэг, өгүүлбэр нь өөрт чинь болоод бусдад хэрхэн нөлөөлж байгааг үнэлэх
5. Төрөл зүйлийн хувьд нэг нь нөгөөгөөсөө ялгарахуйц хэл найруулгын ямар онцлог шинж байгааг харьцуулан жиших
6. Өгүүллэгүүдэд нэг нь нөгөөгөөсөө ялгарахуйц хэл найруулгын ямар онцлог шинж байгааг харьцуулан дүгнэх
7. Зохиол дахь хэл найруулга, уран дүрслэл, яруу хэрэглүүр, бичил дүрслэлийн ямар үүрэгтэй орсныг дүгнэх
8. Энэ үг хэллэг, уран дүрслэл, бичил дүрслэлийг зохиолч хэрэглэснээрээ уншигчдад ийм зүйл хэлж байна \ надад ингэж нөлөөлж байна.\ гэх мэтээр үзэл бодлоо илэрхийлэх
9. Зохиолын хэл найруулгаар дамжин далд утгыг тайлан тайлбарлах
10. Зохиолчдын хэл найруулга дүрслэх арга барилын онцлогийг эшлэл ашиглан нотлох
11. Хэлэх гэж байгаа санаагаа хураангуйлж, дэлгэрүүлэхэд дүрслэх ур маяг \уран дүрслэл\ яруу хэрэглүүр, бичил дүрслэлийг хэрэглэж найруулж бичих
12. Зохиож, найруулахдаа зохиолоос сонгож авсан үг хэллэг, бичил дүрслэл, дүрслэх ур маягаа хэрэглэж сургах

Монголын орчин үеийн уран зохиолын сонгодог бүтээлүүд байна.  
Д.Нацагдорж,  
Б.Явуухулан,  
Б.Лхагвасүрэн,  
С.Эрдэнэ,  
Ш.Сүрэнжав,  
Д.Намдаг,  
Ч.Лодойдамба,  
Л. Түдэв,  
Д.Норов,  
До.Цэнджав,  
Л.Өлзийтөгс нарын зохиолоос сонгох

**Багшийн анхаарах зүйл:**

Бүрэн дунд боловсролын хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ шинжлэх ухааны тогтолцоонд суурилсан арга зүйг баримжаалах бөгөөд аливаа зүйлийг хийж, судлахад явцуу хүрээнд баригдахаас сурагчдыг чөлөөлж... сурах хөдөлмөрөө зохион байгуулах арга эзэмшихэд нь суурь болж өгнө гэж заасан байгаа. Явцуу хүрээнд баригдахаас сурагчдыг чөлөөлөх энэ үйл явц нь

уран зохиолын хичээлийн тайлан тайлбарлах арга зүйтэй нягт уялдаж байгаа юм. Зохиолын утга санааны талыг шинжлэн судлах ухаан буюу уран сайхны үзэгдлийг тайлж тайлбарлах арга зүй болох герменевтик /Херменевтик/-ийн онол<sup>2</sup>-ын хамгийн эхний суурь ухагдахуун нь ойлголт. Тайлан тайлбарлах үйл нь дараагийн шат. Зохиолын ил далд утга, зорилго, дүрслэл дэх өгөгдөхүүнийг тайлах нь герменевтикийн зорилго юм.<sup>3</sup> Тайлан тайлбарлах үйл нь голдуу хувь хүний үйл байдаг байна. Тухайн суралцахуйн зорилтын хүрээн дэх задлан шинжлэх даалгаарыг хийх, асуултад хариулах, хариултаа баримтаар батлах нотлох, үзэл бодлоо илэрхийлэх зэрэг үйл ажиллагааг ахлах ангид илүү чөлөөтэй байлгаж, баригдмал байдлаас аль болох зайлсхийж чиглүүлэх нь чухал гэдгийг багш бид ойлгох хэрэгтэй. Энэ суралцахуйн зорилтыг хэрэгжүүлэхийн эхний алхам яруу хэрэглүүр, бичил дүрслэл, уран дүрслэлийн утгыг ухварлаж сургах юм. Уншигчдад үзүүлэх нөлөөг суралцагчид

- Уншиж байгаа зүйлийнхээ утгыг ухварлаж сурах
- Мэдэхгүй үг хэллэгээ тольчлон тайлбарлах, утгыг ойлгох
- Зохиож найруулахдаа хэрэглэж, үгийн баялгаа нэмэгдүүлэх
- Хэлэх үг, хийх үйлдлээ хянаж, хандлагаа өөрчлөх гэсэн дөрвөн зүйлийн хүрээнд ойлгох нь зүйтэй.
- Үгийн утгыг шилжүүлнэ, уран дүрслэл байна гэдэг нь далд утга байгааг баталж өгдөг. Үүний нэг илэрхийлэл нь бэлгэдэл. Бэлгэдэл нь дүрслэлийн уран хэрэглүүрийн үүрэгтэйгээс гадна тогтолцоот үзэл байдаг. Бэлгэдлийг соёлын уламжлалд тулгуурласан, соёлын уламжлалд тулгуурлаагүй гэж авч үзэх нь ч бий.

Бэлгэдлийг “Бууж мордох хорвоо”, “Өвгөн шувуу”, “Цагаан сар ба хар нулимс”, “Тамгагүй төр” зохиолуудын нэрсээс харж болно. Үдээр байгаа. \

Зохиолуудад бэлгэдэл агуулсан өгүүлэмж байдаг. “Бууж мордох хорвоо” өгүүллэгт халуун хошуут малыг бэлгэдэх ёсны тухай хоёр ч өгүүлэмж бий. Нэг нь “Энэ хойд дээгүүр гараад ирсэн чинь далай цагаан хонь налайж харагдахаар нь баярлаж л байлаа.” гэсэн Самбаагийн үг, нөгөө нь нас барагсдыг нутаглуулах замд халуун хошуут мал /хонь, адуу/ тааралдвал “Талийгч буйнтай хүн байжээ” гэж бэлгэшээн үздэг монгол ёсны бэлгэдэл бийг санан Хангай өвгөнийг нутаглуулах замд далай цагаан хонь, адуун сүргээ бэлчээрлүүлж байгаа Төгөөгийн үйлдэл юм.

“Тамгагүй төр” жүжгийн эхлэл, төгсгөл хэсгийн горимд, өрнөл хэсэгт Гүргэл хатны үгэнд хэрээ шувууг оруулсан нь бий. Жүжгийн эхлэл хэсэгт “Зээлэн суусан хүмүүс дунд цас цагаан өмсгөлт сая төрсөн хоёр эм, гөрөөсний арьсан өлгийтэй ихэр мэт хүүхэд нэг нэгээр тэврэн суух нь олон хэрээнүүд дундах хун мэт харагдана.” гэсэн бол өрнөл хэсэгт:

Үгүй надад нэг л

Хар совин толгойд хэрээчилж

Хажуунаас чинь явмааргүй ч юм шиг гэсэн байна. Харин жүжгийн төгсгөл хэсэгт “Арчуг илдээ Эгэрэгт дүрэхэд Эгэрэг илдээ Арчугт дүрнэ. Хоёр илдэнд сүлбүүлсэн хоёр хүний силуэт. Дундуур нь хаан сэнтий алтран харагдана. Хэрээний дуу тэгснээ хөгжим нүргэлэн эгшиглэнэ.” гэж дүрсэлсэн нь хэрээ шувууг цөвүүн цагийн бэлгэдэл болгожээ гэж тайлан тайлбарлаж болно.

Уран дүрслэлийн тойруулал, төлөөлөл, адилтгалын жишээ нь далд утгыг тайлан тайлбарлах бас нэг хэрэглүүр юм.

Үлгэрлэвэл: “Тамгагүй төр” жүжгээс “Хөлд орох анхны алхам нь хүртэл

Хүннү төрийн төлөө байг гэж бодов би

Хэлд орох анхны үг нь хүртэл

Хүннү гэж хэлэг гэж санаа би гэсэн эшлэлийн утгыг “Цус

цэвэрхэн байх, удмын сангаа хадгалж үлдэхийн чухлыг ухааруулсан гэх буюу үг үйлдэл нэг байхаас эх оронч үзэл эхэлнэ эсвэл гэж ойлголоо гэж тайлбарлаж болно. “Нусаа цэвэрлэж чаддаггүй амьтан цусаа цэвэр байлгахыг яаж ч мэдэх вэ?, “Ийм хаантай төр орхино гэхээс ичиж байна би, их хаадын цусан хэлхээ булшнаас нь хүртэл ичиж байна”, “Илд далайхад бяра нь ил хүрэх, их хэрэгт ухаан нь үл хүрэх” гэсэн эшлэлээс далд утгыг тайлахдаа “Биеэ засаагүй хүн төрөө засахгүй, хаан төрийг ухаан залдаг” гэх мэтээр тайлж болно. Энэ бүхний эцэст

<sup>2</sup> Бүрэн дунд боловсролын сургалтын цөм хөтөлбөр. Монгол хэл бичиг, уран зохиол.УБ 2016. 38 дахь тал

<sup>3</sup> Галбаатар .Д. “Уран зохиол: онол, түүх, шүүмжлэл”.УБ. 2012 он. 105 дугаар тал



биеэ зөв засах ухааныг өөртөө бий болгохын төлөө тэмүүлж байгаа нь уншигчдад үзүүлж байгаа нөлөөлөл юм.

**12.1е.**

Яруу найргийн айзам, эгшиглэл, бадаглалыг задлан шинжлэх

Энэ суралцахуйн зорилтын хүрээнд сурагчид айзам хэмжээнд тохируулан шүлэглэсэн уран зохиолын нэг төрөл болох яруу найргийн тухай ойлголтоо гүнзгийрүүлж, айзам, эгшиглэл, бадаглалыг судалж, үнэлгээ дүгнэлт өгөх чадвар эзэмшинэ. Үүнд:

1. Яруу найргийн зохиолын агуулга, хэлбэрийг бүтээхэд айзам хэмнэл ямар үүрэгтэйг тайлан тайлбарлах
2. Шүлгийн эгшиглэл буюу хөг аяыг мэдэрч тайлбарлах
3. Айзам аялгын нэгэн бүхэл бүтэц-зохиомж болсон бадаг хэрхэн бүтэж бүрдсэн хийгээд түүний хэлбэр байгууламж ямар онцлогтой болохыг дүгнэх

Монголын орчин үеийн уран зохиолын сонгодог бүтээлүүд байна.  
Д.Нацагдорж,  
Б.Явуухулан,  
Б.Лхагвасүрэн,  
Н.Нямдорж,  
Ц.Бавуудорж,  
Ц.Хулан нарын уран бүтээлээс сонгох

**Багшийн анхаарах зүйл:**

Энэ зорилтын хүрээнд гурван үйл ажиллагааг санал болгосон. Үйл ажиллагаа тус бүрд дараах арга зүйг зөвлөж байна.

Яруу найргийн зохиолын агуулга, хэлбэрийг бүтээхэд айзам хэмнэл ямар үүрэгтэйг тайлан тайлбарлахдаа

- Хэлний хамгийн бага нэгж авиа нь уран зохиолын найруулга ялангуяа яруу найргийн зохиолд уран сайхны олон талын үүрэг гүйцэтгэдэг болохыг гүнзгийрүүлж тайлбарлана. Энэ чадвараа хөгжүүлэхдээ:
  - ✓ өнгө аяс илэрхийлэх
  - ✓ хөгжим аялгуу шингээх
  - ✓ дүр, дүрслэл бүтээх
  - ✓ дуу чимээ үүсгэх
  - ✓ мэдрэмж, хандлага илэрхийлэх
  - ✓ дүрийнхээ сэтгэл санааны далд давтагдашгүйг нээхэд чухал үүрэгтэйг таньж тайлбарлах нь чухал. Жишээ нь: Ш.Сүрэнжав “Тэнгэрийн хүү”

“...Цагийн бороо тэнгэрээс асгарахад

Хөхин баясаж,

утас дамжих шиг

усан ширхгээр нь авиран гарч

оддыг сондор болгон хэлхэж

цэцгийн толгойд зүүж өгч явсан...” шүлэгт авиа ба үг хэллэгийн өвөрмөц сонголт,

эрчим, бахдалын аяс хандлагыг авиа зохицуулан өвөрмөц сэтгэж үүсгэсэн төдийгүй “утас дамжих шиг усан ширхгээр нь авиран гарч...” гэсэн алгуур аажим, хийсвэр мэт үйлийн эрчим, хөдөлгөөн мэдрэгдэж, “оддыг сондор болгон хэлхэх” санаанд оромгүй үйлд уяж, улмаар цэцгийн толгойд зүүх бодит юм шиг, хүсэл юм шиг, баяр хөөртэй дүр зураг бүхнийг шингээж урласан нь яруу найргийн үг сонголт, айзам хэмнэл, бадаглал, эгшиглэлтэй амь мэт уяатай байгааг олж тайлбарлах нь чухал.

Авиа нь уран дүрслэлээр дамжин илрэх боломжгүй, зөвхөн мэдрэхүүд өртөгдөх нарийн

мэдрэмж, өнгө аясыг ялгаруулан тодруулахад тусалдгийг тайлбарлах нь чухал. Жишээ нь:

П.Бадарч “Эхийн сэтгэл”

“...Хүний нүдэнд бол

Хөгцтэй хад шиг

Хөх толгойтой

Хөгшин хүү минь

Ижийнхээ нүдэнд бол

Манцуйдаа тарвалзах

Мяндас цагаан хүү минь...” шүлэгт үрдээ хандах ээжийн зөөлөн эвээрүү зан ааль, хайр

өхөөрдлийн өнгө аяс илэрхий тод туссаныг гаргахдаа дүрслэл, эсрэгцлийг чадамгай

хослуулсан байгааг гаргаж тайлбарлах нь чухал.

Яруу найргийн айзмыг сэтгэлгээ, сэтгэл хөдлөлийн айзам буюу гоо сайхны учир холбогдолтой бүхий айзам, хэлний буюу авианы айзам гэх зэргээр ялгадаг. Эхнийх нь яруу найргийн агуулгыг илэрхийлэх зорилгоор хөгжим аялгуу, аяс хандлагыг нээхэд, удаах нь шүлгийн илэрхийлэл болон хэлбэрийг бүтээхэд ашигладаг онолын ойлголтыг сурагчид гүнзгийрүүлж тайлбарлаж сурвал бас сайн.

Яруу найргийн шилдэг зохиол нь хэн бүхэн шууд ухааран тайлж, эцсийн ганц дүгнэлт хийж болох тийм бүтээл бус олон тайлал, олон хариу шаардсан, өвөрмөц шинэ орон зай, нууцас руу нэвтрэхийн хэрээр шүүмжлэл, онолын олон олон хариулт нэхсэн, бодрол, санал сэтгэгдлийн шинэ шинэ тайлал шаардаж түүнийхээ хэрээр төгс шинжтэй болдог тийм нэг бүтээл юм. Иймээс сурагчдын шүүмжлэлт сэтгэлгээ болон задлан шинжлэх чадварыг нь хөгжүүлэхэд онолын ойлголтуудыг ашиглах боломжтой гарын авлага, цахим хэрэглэгдэхүүнтэй сургалтын орчинг бүрдүүлэх нь чухал. Сурагчид өөрийн судалгаат уншлагын чадвараар хөгжүүлэхийн зэрэгцээ ялгаатай үзэл санааг хуваалцах чадварт суралцах нь хамгийн чухал болохыг дахин дахин санаж байгууштай.

Үг нь хэд хэдэн авианы нэгдлээс бүрдэж, авиа бүр өөр өөрийн хөг аялгуу, сонсголон, ая эгшиглэлтэй тул дүр бүтээж, дүрс илэрхийлэх үүрэг гүйцэтгэдэг. Энэ нь яруу найргийн зохиолд тод илэрч, авианы аялгын тусламжтай би баатрын зан төрхийг бүтээх, онцлогийг гаргахаас гадна авианы бүлэглэл нь цаг үе байгаль, цаг улирлын аяс, хүний сэтгэлийн дотоод, гадаад байдлын уялдаа холбоо, амьдралын орчин, үүссэн нөхцөл байдлыг илэрхийлэхэд тусалдаг талаас нь ойлгож сурагчид тайлбарлах нь чухал юм.

Айзам аялгын нэгэн бүхэл бүтэц-зохиомж болсон бадаг хэрхэн бүтэж бүрдсэн хийгээд түүний хэлбэр байгууламж ямар онцлогтой болохыг дүгнэхдээ:

“Аялга ба холбоцын нэгэн хэм зохицолд захирагдаж, тодорхой утга төгссөн хоёр буюу хэд хэдэн шадаас бүрдсэн айзам- өгүүлбэр зүйн нэгжийг шүлэг судлалд бадаг гэнэ” (Д.Галбаатар) гэсэн бадаглалын тухай ойлголтыг сурагчид өмнөх ангиуддаа сайтар судалсан, энэ талын ойлголт сайтай байдаг. Шүлгийн үндсэн суурь нэгж нь бадаг тул шүлгийн эхний бадгийн бүтэц тодорхой давтамжтайгаар дахин давтагдаж шүлгийг бүтээдэг зүй тогтол нь шүлгийг эмх цэгцтэй, тодорхой бүтэцтэй, эрэмбэтэй, тухайн үндэстнийхээ соёл сэтгэлгээний онцлогийг илэрхийлдэг онцлогийг гаргах нь ахисан түвшний даалгавар болох юм. Монгол шүлгийг тэгш ба сондгой тоотой мөрүүдээр бадаглахын зэрэгцээ тодорхой хэмнэлээр айзам үүсгэж, шүлгийн мөрүүдийг ар араас нь угсруулан холбож бадагладаг онцлогтой. Нарийн чанд бадаглалгүй дотоод айзам хэмнэлийн аясаар чөлөөтэй шүлэглэсэн зохиолыг задгай шүлэг гэж нэрлэдэг. Үйл явдлын өрнөлтэй шүлгүүдийг ихэвчлэн задгай хэлбэрээр бичих хандлага байдаг. Жишээ нь: П.Бадарч “Эхийн сэтгэл” шүлэгт эхлэл хэсэгтээ

“Ижий нь муу хүүгээ үхэж гэж зүүдэллээ

Ийм аймаар зүүд ная наслахдаа зүүдлээгүй

Сааль сүүндээ дэвэлзсэн ч

Санаа сэтгэл дэгэлзсэн ч

Сарних бодлын үзүүрт үр минь торойно

Сайхан шүлэг бичиж гэнэ миний хүү

Амьтан хүн уншиж байна

Сайхан дуу зохиож гэнэ миний хүү Араажаваар дуулж байна лээ

Сайн явна гэнээ миний хүү

Аяны хүн хэлж байна

Муу явна гэнэ миний хүү

Амны зугаа ярьж байна

Аль нь ч надад ялгаагүй ээ

Амьд яваа нь л ижийдээ

Алдар чинь шүү дээ...” гэж толгой холболтыг ашигласан бол цаашид

“...Хүний хүү ижийдээ ирж гэнэ ээ

Гол усаар л нэг найр

Наадам болж байна

Миний хүү шоронд орж гэнэ

Голыг минь гогодон хэлж байна

Аа яадгийм ороо л биз гэж

Гадагшаа би хүүгээ өмөөрлөө

Ам нь цангаж байгаа байх даа

Муу хүү минь гэж

Дотогшоо би өмөлзлөө...” гэх мэтээр задгай шүлгийн бүтцийг ашиглаж айзам хэмнэлийн аясаар чөлөөтэй шүлэглэхдээ эсрэгцлийг түлхүү ашигласан онцлогийг гаргах нь ахлах ангийн сурагчдын хувьд ахисан түвшний чадвар болох юм. Задгай шүлэгт сүүл холбоцыг бас онцолж тайлбарлах хэрэгтэй.

Яруу найргийн зохиолын дүр дүрслэлийг тодорхой ойлгож, шүлгийн агуулга, үзэл санааг тайлбарлаж, үгийн утга, уран сайхны үнэ цэнийг зөв тайлбарлаж, дүгнэж, шүлгийн онцлогийг тодорхойлж чадаж байх нь чухал.

## ХОЁР. БИЧИХ ЧАДВАР

Суралцахуйн зорилт	Сурах үйл ажиллагаа	Хэрэглэгдэхүүн
<b>12.2а.</b> Зохиолын хэлний хэрэглээг задлан шинжилж, нэгтгэн дүгнэж бичихдээ жишээ, тайлбар, нэр томъёог оновчтой хэрэглэх	<p>А.Үгийг хэрхэн сонгож хэрэглэснийг судлах</p> <ol style="list-style-type: none"><li>1. Уншсан зохиолынхоо өвөрмөц, хэлц, содон, танил биш, уран үг хэллэгүүдээс сонгор</li><li>2. Зохиолч ямар зорилгоор эдгээр үгсийг сонгосныг тайлбарлах, дээрх үгсийг хэрэглээгүй байсан бол ямар утга алдагдах бол гэж хэлэлцэх</li><li>3. Сонгосон үг нь баталсан, нотолсон баярласан гомдсон өнгө аястай байгааг, дүрийн зан төрхийг илэрхийлж байгааг хэлэлцэх</li></ol> <p>Б.Яруу хэрэглүүрийг хэрхэн хэрэглэснийг судлах</p> <ol style="list-style-type: none"><li>1. Толгой, сүүл холбохдоо ямар үгийг хэрэглэснийг ажиглах</li><li>2. Бөгжин, бэлчирлүүлэх давталтыг хийхдээ үгээ хэрхэн сонгосныг ажиглах</li><li>3. Яруу асуулт, яруу дуудал, яруу хандлаа илэрхийлэхдээ ямар үг сонгосныг ажиглаж, хэр оновчтой байгаа талаар хэлэлцэх</li><li>4. Санааг илэрхийлэхдээ ахиуллын, харшууллын ур маяг хэрэглэсэн эсэхийг нягтлах</li><li>5. Өгүүлбэр зүйн хувьд зэрэгцүүлснийг ажиглаж, зэрэгцүүлэл болж байгааг батлахдаа үгийг ажиглах</li></ol> <p>В.Уран дүрслэлийг боловсруулахдаа ямар үг сонгосныг ажиглах</p> <ol style="list-style-type: none"><li>1. Адилтгахдаа, хэтрүүлэхдээ, ёгтлохдоо, егөөдөхдөө, тойруулж \бусад ур маяг\ хэлэхдээ ямар үг сонгосныг ажиглаж, зохиолч ямар зорилгоор ийнхүү дүрсэлснийг тайлбарлах</li></ol> <p>Г.Бичил дүрслэлийг судлахдаа:</p> <ol style="list-style-type: none"><li>1. Дүр, орчноо дүрслэхдээ тэмдэг нэрээр тодруулсан үг хэллэгийг ажиглах. Тухайлбал, Д.Нацагдоржийн “Ламбугайн нулимс” зохиолд “урин тачаангуйн хурц илдийг боловсруулахын...” гэсэн хэсэгт илд гэж зэвсгийн утгатай үгийг сонгохдоо Цэрэнлхам бүсгүйн ааль авирыг хурц зэвсэг мэт адилтгаад, тэрхүү шинжийг улам нарийвчлан дүрслэхдээ урин, тачаангуйн, хурц гэсэн тэмдэг нэрийг хэрэглэсэн нь бичил дүрслэлтэйг харуулж байна.</li></ol> <p>Д. А,Б,В,Г хэсэгт хийсэн үйл ажиллагаагаа нэгтгэн дүгнэж бичих</p> <ol style="list-style-type: none"><li>1. Нэгтгэн дүгнэхдээ дараах байдлаар бичнэ. “Зохиолч үгийг .... ийм зорилгоор хэрэглэсэн нь зохиолыг улам уран сайхан болгожээ. Энэ үгийг</li></ol>	Задлан шинжилж, нэгтгэн дүгнэж бичсэн жишээ загвар эх

	<p>урнаар дүрслэхдээ хэрэглэсэн нь их оновчтой байна” гэх зэргээр өөрийн үзэл бодлоор дүгнэнэ.</p> <ol style="list-style-type: none"> <li>Дүгнэхдээ жишээ, тайлбар, нэр томъёог оновчтой хэрэглэх</li> <li>Ноороглох</li> <li>Ноороггосноо засах, зөв бичгийн дүрмийн болон найруулгын, логикийн, баримтын засвар хийх</li> <li>Дахин сийрүүлж бичих</li> <li>Хэрхэн бичсэнээ өөрөө үнэлэх, бусдад илэрхийлэх</li> </ol>	
<p><b>Багшийн анхаарах зүйл:</b>  <i>Хэлний хэрэглээг судална гэдэг нь зохиолчийн зүгээс уншигчдад нөлөөлөхийн тулд хэрхэн холбоо тогтоож байгааг шинжилнэ гэсэн үг. Хэлний хэрэглээ гэдэгт:</i></p> <ol style="list-style-type: none"> <li><i>Үг сонголт /үгсийн дуудлага-diction, өнгө аяс-tone судлах/</i></li> <li><i>Өгүүлбэр зүйн ур маягууд /өгүүлбэрийн доторх үгсийн байрлал, яруу хэрэглүүрийн үүргийг судлах/</i></li> <li><i>Уран дүрслэлийн ур маягийг судлах</i></li> <li><i>Бичил дүрслэлийг судлах<sup>4</sup> Эдгээрийн тухай ойлголтоо нэмэгдүүлэхдээ Г.Нандинбилиг, “Хүүрнэл зохиолыг задлан шинжилж сургахуй” номыг хэрэглээрэй.</i></li> </ol> <p><i>Бичил дүрслэл гэдгийг нарийвчлал, нарийн ширийн дүрслэл гэж ойлгоно. Зохиолч дүрээ, орчноо илүү тод ТОДОТГОН дүрслэхийн тулд үг хэрэглэдгийн нэг жишээ нь тэмдэг нэр юм. Тиймээс тэмдэг нэрээр илэрсэн үгийг зохиолч ямар зорилгоор хэрэглэснийг ажиглуулж, дүгнэлт гаргуулахад багш анхаарна.</i></p> <p><i>Дэмжлэг болох асуулт:</i></p> <ul style="list-style-type: none"> <li>- <i>Зохиолч юуг хэлэхийг хүсэж, дүрээ бүтээхдээ дүрслэлт үгийг хэрэглэсэн бэ?</i></li> <li>- <i>Хэрвээ тухайн үгийг зохиолч сонгож хэрэглээгүй байсан бол зохиолын утга санаа хэр өөрчлөгдөх бол?</i></li> <li>- <i>Зохиолч үгийн сангийн бүрэлдүүлбэрүүдээс ямар үгийг ямар зорилгоор сонгосон бэ? Ойролцоо, эсрэг, ижил, хуучин, шинэ, мэргэжлийн, харь, нутгийн аялгууны, этгээд, бүдүүлэг, төсөөт, тонгоруу үг, хэвшмэл ба өвөрмөц үг хэллэг, хэлц гэх мэт</i></li> <li>- <i>Урнаар дүрсэлсэн хэсгийг яаж таних вэ? Адилтгасан, хэтрүүлсэн, егөөдсөн, бэлгэдсэн г.м байна уу?</i></li> <li>- <i>Жүжгийн зохиолыг уншсан бол цэг тэмдгийг ямар зорилгоор хэрэглэсэн бол?</i></li> </ul> <p><i>Зохиолын хэлний хэрэглээг үнэлж, тайлан тайлбарлаж бичихдээ холбогдох нэр томъёог хэрэглээрэй.</i></p> <p><i>Яруу хэрэглүүрийн бүтэц нь 2 янз байна.: 1. Найруулгазүйн ур маягууд, 2. Өгүүлбэрзүйн ур маягууд.</i></p> <p><i>Найруулгазүйн ур маягуудад дараах зүйл орно.</i></p> <ol style="list-style-type: none"> <li><b>1. Ерийн давталт</b> Аль нэг үгийг давтах ёс</li> <li><b>2. Толгой холболт</b> Эхний авиаг давтах ёс</li> <li><b>3. Сүүл давталт</b> Сүүлийн үг, авиа давтах ёс</li> <li><b>4. Бөгжин давталт</b> Шадын эхийг сүүлд нь давтах ёс</li> <li><b>5. Бэлчирлүүлэх давталт</b> Шадын адгийг эхэнд нь давтах ёс</li> </ol> <p><i>Өгүүлбэр зүйн ур маягууд.</i></p> <ol style="list-style-type: none"> <li><b>1. Ахиуллын ур маяг</b> Хүмүүсийн хоорондын харилцаанд сэтгэлийн хурц хөдөлгөөн өрнөж, түүний илэрхийллийг дуугүй, маш товч үгээр хэлэн өнгөрүүлэхийг хэлнэ. Жишээ нь: Д.Нацагдорж “Хэрэв би морьтой болоод завтай сан бол доо...”</li> <li><b>2. Яруу асуултын ур маяг</b> Уншигчаас ямар нэгэн хариу авах гэсэндээ биш яруу сайхны учир зорилготой орсныг хэлнэ. Жишээ нь: Ц.Чимиддорж “Сэлбэ” шүлэгт Чулуун арслангаас өөр өмөөрөх эзэнгүй юм бол Чухамдаа тэгээд энэ чинь хэний гол юм бэ...</li> <li><b>3. Яруу дуудлын ур маяг</b> Ямар нэгэн зүйлийг сэтгэлийн хөдөлгөөний хэлбэрээр баталсан юм уу, үгүйсгэсэн чанартай ур маяг. Жишээ нь: В.Инжинаши “Сул” шүлэгт Хүний сэтгэлийг хөдлөлгөж эс чадваас Хөнгөн бийрийг хөшиж юу хиймэй</li> </ol>		

<sup>4</sup>Г.Нандинбилиг, “Хүүрнэл зохиолыг задлан шинжилж сургахуй”, 2016 он, 44-р тал

4. **Яруу хандлын ур маяг** Яруу найрагчийн зүгээс бодит байдлын үзэгдэлд яруу сайхны учир зорилго бүхий хандаж буй ур маягийг хэлнэ. Жишээ нь: Д.Нацагдорж “Од” шүлэгт Холхи газраас гялалзах харагдах өнгөт од оо Хязгааргүй огторгуйн дунд зугаалагч олон улаан оч оо
5. **Харшуулах ур маяг** Эсрэг тэсрэг хоёр үзэгдлийг харшуулан дүрсэлж, дотоод зөрчлийг ялгаруулан дүрслэх аргыг хэлнэ.
6. **Өгүүлбэрзүйн зэрэгцүүлэл** Жишээ нь: Ардын дуу

Шалгуур	Тийм	Үгүй	Ямар алдаа гарав? Нотлох баримт	Яаж засах вэ?	Багшийн зөвлөгөө
Хэлний хэрэглээг задлан шинжилсэн үү?					
Бичихдээ нэр томъёо, жишээ, тайлбар хэрэглэсэн үү?					
Бүтцийн хувьд эхлэл, гол, төгсгөл хэсэгтэй байна уу?					
Цогцолбор бүрт нэг утга санаа илэрсэн үү?					
Цогцолборуудыг холбох үгээр зөв холбосон уу?					
Цогцолборыг эхлэхдээ догол мөр гаргасан уу?					
Ноорогдосон уу?					
Зөв бичгийн дүрмийн алдаагүй байна уу?					
Утгын алдаагүй байна уу?					
Дахин сайжруулж бичсэн үү?					
Оноосон нэрийг томоор бичсэн үү?					
Үгийг олон давтаж нуруу бичсэн байна уу?					
Үгсийг утгаар нь буруу холбосон байна уу?					

<p><b>12.26.</b> Зохиолын хэлбэр, бүтэц, хэл найруулгаас суралцан, уран дүрслэл ашиглаж, санаагаа төгсгөн бичих</p>	<ol style="list-style-type: none"> <li>Уншсан зохиолуудаас сонгон, хэлбэр, хэл найруулгын талаар ярилцах</li> <li>Ямар сэдэвтэй, ямар асуудал дэвшүүлэхээ төлөвлөх, хэлэлцэх</li> <li>Уншигчдад ямар санаа дэвшүүлэхээ ярилцах, илэрхийлэх гол санаагаа ярилцах. Тухайлбал, Уншигчдад юуг хэлэхийг хүсэж байна вэ? гэж бодох</li> <li>Эхлэл, гол, төгсгөл хэсэгт ямар ямар үйл явдал гаргаа төлөвлөх Эхлэл хэсэгт дүрийнхээ зорилго, гадаад дүр байдал, зан чанарыг танилцуулж, дүрсэлж бичих Гол хэсэгт баатруудад тохиолдсон явдлаа, тэдэнд тохиолдсон бэрхшээл, бэрхшээлийг даван гарсан тохиолдлууд, баатрууд боломжийг ашиглаж байгаа үйл явдлууд, баатруудын хоорондох харилцан яриа зэргийг зохиох, зохиосон үйл явдлаа цогцолборуудад хуваах Төгсгөл хэсэгт уншигчдад юуг хэлэх гэж байгаагаа дүгнэж бичих</li> <li>Төлөвлөсний дагуу ноороглох</li> <li>Нооргоо засах. Найруулгын засвар хийхдээ баримтын засвар, учир шалтгааны алдаа байгаа</li> </ol>	<p>Задлан шинжилж, нэгтгэн дүгнэж бичсэн жишээ загвар эх</p>
---	---	--

	эсэхийг хянах, гоо зүйн алдаа гаргасан эсэхийг хянах. Зөв бичгийн дүрмийг зөв хэрэглэснийг хянах 7. Дахин сийрүүлж бичих 8. Хэрхэн бичсэнээ өөрөө үнэлэх, бусдад илэрхийлэх	
--	---	--

**Багшийн анхаарах зүйл:**

Өмнөх бичих чадварын хичээл нь задлан шинжилснээ, судалснаа бичих зорилготой байсан бол энэхүү суралцахуйн зорилт нь сурагчдаас зохиож бичих чадварыг шаардана. Хүүрнэн бичих гэж яаж бичихийг хэлэх вэ, бичихдээ юуг алгасаж, товчилж бичих вэ гэсэн асуудлыг багш сурагчдын өмнө сэдэлжүүлнэ. Хүүрнэж бичнэ гэдэг нь ямар нэгэн хэрэг явдлыг учир шалтгааны дарааллаар өгүүлэхийг хэлнэ. Эхлэл, гол буюу өрнөл хэсэг, төгсгөл буюу дүгнэлт хэсгүүдэд үйл явдлын дэс дарааллыг өгүүлдэг. Аливаа ээлжит хичээлд амжилттай суралцуулахын тулд ЮУГ, ЯАЖ хийх аргыг сайтар ярилцаж, ухааруулсны дараа үйл ажиллагаанд татан оролцуулах нь үр дүнтэй болохыг олон улсын сургалтад анхаарсаар иржээ. Дараах амжилтын шалгуурыг хэрэглэхийг санал болгож байна.

Бичих үйлийн алхам	Зайлшгүй мэдэх онолын ойлголт	Хэрхэн бичсэнээ шалгах шалгуур
Туршиж бичиж байгаа зохиолдоо ямар сэдвийг хөндөж бичихээ эргэцүүлэх	Сэдэв: Дэвшүүлсэн асуудал	Юуны тухай бичсэнээ бодсон уу? Ямар асуудлыг дэвшүүлсэн бэ?
Бичих санаагаа эргэцүүлэн бодох, бусадтай хэлэлцэх	Гол санаа: Уншигчдад төрөх ойлголт	Зохиосон үйл явдлаар уншигчдад хэлэх гэсэн санаа нь тодорхой илэрч байна уу? Уншигчид бичсэн зохиолоос нь ...ийм л утгыг илэрхийлжээ гэж бодоход хүрэх болов уу?
Санаагаа байрлуулж, төлөвлөгөө гаргах	Эхлэл, зангилаа, өрнөл, туйл, тайлал, төгсгөл. Цогцолбор, догол мөр, цогцолборуудын хоорондох утгын уялдаа холбоо, холбох үгс	Өгүүлэгдэхүүний хувьд эхлэл, зангилаа, өрнөл, туйл, тайлал, төгсгөл хэсэгтэй байна уу? Эсвэл аль нэг бүтцийг алгасаж, эсвэл товчилсон уу? Эхлэл хэсэгтээ дүр, орчноо танилцуулсан уу? Зангилаа, өрнөл хэсэгтээ баатруудад тохиолдсон явдал, бэрхшээл, түүнийг даван туулсан тухай, эсвэл боломж, түүнийг ашигласан тухай, баатруудын харилцан яриа, зөрчил, эвлэрэл зэргийг бүтээсэн үү? Төгсгөл хэсэгтээ гол санаагаа дэвшүүлсэн үү? Эсвэл өөр хэсэгт дэвшүүлсэн үү?
Төлөвлөсний дагуу ноороглон бичих	Ноороглон бичнэ гэдэг нь бичих үйл ажиллагаанд чухал байдаг тул олон цагийг төлөвлөх хэрэгтэй юм.	
Бичсэнээ нягталж, найруулгын болон зөв бичгийн дүрмийн алдаагаа засах	Найруулгад тавих шаардлага, зөв бичгийн дүрэм	Ойлгомжтой байгаа эсэх, үг өгүүлбэр нэмэх үү, үг өгүүлбэр хасах уу, үгийн байрлал солих уу, үгийг солих уу, утга зүй болон баримтын, гоо зүйн алдаа байна уу, зөв бичгийн дүрмийн ямар алдаа гаргав, яаж засав, дүрмийн бус үгийг хэрхэн бичив гэх мэт
Дахин сийрүүлж бичих, шалгуурын дагуу засах		

**ГУРАВ. СОНСОХ-ЯРИХ ЧАДВАР**

Суралцахуйн зорилт	Сурах үйл ажиллагаа	Хэрэглэгдэхүүн
<p><b>12.3а.</b> Уншсан зохиолын хам сэдвийн хүрээнд үзэл бодлоо илэрхийлэн мэтгэлцэх</p>	<ol style="list-style-type: none"> <li>1. Уншсан жүжгүүдээс нь тайз дэлгэцийн бүтээл болсон зохиолуудыг сонгох</li> <li>2. Мэтгэлцэхээс өмнө зохиолын утгыг сайн ойлгож унших, уншсанаа ярилцсан байх</li> <li>3. Зохиолд нийгэм, соёл, түүх, шашны ямар хам сэдэв дэвшүүлэгдсэнийг задлан шинжилсэн байх</li> <li>4. Сурагчдыг илтгэгч буюу нотлогч баг, няцаах баг, шүүгч гэсэн бүтцийн дагуу хуваарилна.</li> <li>5. Шүүн хэлэлцэх сэдэв буюу “ШИЙДЭЛ”-ээ танилцуулах</li> </ol> <p>Шийдлийн жишээ: Дүрүүдийн хийсэн үйлдэл, шийдвэр нь зөв эсвэл буруу, зохиолчийн дэвшүүлсэн асуудал нь нийгмийг сэрээсэн, зохиолч жүжгийн зөрчлийг сайн зохиомжилсон, жүжигт ямар ч зорилгогүй дүр байсан гэх мэт</p> <ol style="list-style-type: none"> <li>6. Дэвшүүлсэн шийдлийн хүрээнд нотлох баг илтгэлээ танилцуулна. Илтгэлд тавигдах шаардлагыг монгол хэлний хичээлийн агуулгатай интеграцилан багш харгалзан үнэлнэ.</li> <li>7. Няцаах баг илтгэлийг сонсон, нотолгоонуудыг жишээ татан няцаах, ямар учраас зөвшөөрөх боломжгүйгээ жишээ татан асуудлаа дэвшүүлэх</li> <li>8. Нотлох баг харилцан мэтгэлцэж, байр сууриа хамгаалахад бэлдэх</li> <li>9. Шүүгч нь талуудын дэвшүүлсэн нотолгоонуудаас сонгон, хамгийн үнэмшилтэй, үнэн, зөв болсныг шийдвэрлэх</li> <li>10. Шүүгч мэтгэлцээний талаар талуудад зөвлөгөө өгөх</li> </ol>	<p>С.Эрдэнэ “Өвгөн шувуу”, Л.Өлзийтөгс “Аквариум”, Д.Намдаг “Хөгшин чоно ульсан нь”, Ч.Галсан “Аянгат цагийн тууж” болон дээрх зохиолууд</p>
<p><b>Багшийн анхаарах зүйл:</b> Мэтгэлцэх чадварт сургахын тулд багш сурагчдыг хэрхэн шүүмжлэлт сэтгэлгээтэй болгох вэ?, Ер нь шүүмжлэлт сэтгэлгээ гэж юу хэлэх вэ? Энэхүү ойлголтын үүднээс яаж хөгжүүлэх вэ? Мэтгэлцэнэ гэж ямар чадварыг хэлэх вэ? Мэтгэлцэж сурсан хүүхэд гэж ямар сурагчийг хэлэх вэ? гэсэн асуултыг багш эргэцүүлж, асуултаа боловсруулж, өөрийн үйл ажиллагаагаа чиглүүлнэ. "Мэтгэлцэнэ" нь дэвшүүлсэн тухайн сэдвийг нотлох тал дэмжих ба эсрэг тал нь няцаах тодорхой хязгаарлалт, загвар бүхий нотолгоо дэвшүүлэх тэмцээн юм. Мэтгэлцэнэ нь олон талаас шүүн хэлэлцэх сэдэв буюу "ШИЙДЭЛ"-ээс эхэлнэ. Шийдлийг дэмжиж буй тал буюу нотлох багийн илтгэлийг эхлээд сонсоно. Эсрэг тал буюу няцаах баг нь нотлох багийн нотолгоонуудыг няцаах ба шийдлийг ямар учраас хүлээн авах боломжгүй болохыг батлан харуулсан нотолгоонуудыг дэвшүүлэх үүрэгтэй. Цаашид талууд бие биеийн дэвшүүлсэн нотолгоонуудад харилцан хариулт өгч байр сууриа хамгаалснаар мэтгэлцэнэ өрнөх юм.</p>		

Төвийг сахисан гурав дахь тал болох "ШҮҮГЧ" нь талуудын дэвшүүлсэн нотолгоонуудыг анхааралтай сонссоны үндсэн дээр аль тал нь хамгийн үнэмшилтэй хүчтэй нотолгоо дэвшүүлсэн талаар шийдвэр гаргадаг юм. Шүүгч нь мэтгэлцээний дараа талуудад зөвлөгөө өгнө. Мэтгэлцээн нь хичээлд болон хичээлээс гадуур ашиглаж болох бие даан суралцах аргын нэг бөгөөд сургалтын хамгийн идэвхтэй аргын нэг юм.<sup>5</sup>

Ахлах ангийн сурагчдад уран зохиолын хичээлээр өгөх асуулт, даалгавраас тэдний мэдлэг чадварын чанар ихээхэн шалтгаалдаг. Багш аль болох цаана нь байж болох далд утгыг гаргаж чадсан эсэхээр нь үнэлж дүгнэж байвал хүүхдүүд бас л тийм нарийн зүйлийг эрж хайж уншиж, түүнийхээ талаар мэтгэлцдэг болно. Уран зохиолын хичээлийг хэлэлцүүлэг, мэтгэлцээн хэлбэрээр явуулж байвал сурагчид бие биеэсээ маш их зүйлийг сурч, өөр өөр өнцгийн санаа оноо шийдлийг олж, улмаар түүнийгээ цааш хөгжүүлж байдаг. Уран зохиолын хичээл бол зөвхөн тухайн хичээлийн цагаар биш хэлэлцэж ярилцсан зүйл нь байнга эргэлдэж, илүү ихийг мэдэхийг олохын эрэлд хатааж байвал сая үүргээ биелүүлж байгаа хэрэг. Энэ суралцахуйн зорилт нь сурагчдыг байнгын бүтээлч эрэл хайгуулд хөтөлж, сэтгэлгээг задалж, олон олон өнцгийн байр сууриас асуудалд хандахад сургах тул сурагчдын ярих чадварыг зөвхөн ойлгосноо эсвэл хэн нэгэн судлаачийн үгийг дахин давтан тайлбарлах байдлаар шийдвэрлэхгүй байх нь багш нарын зайлшгүй анхаарах асуудал юм. Энэ суралцахуйн зорилтыг эзэмшсэнээр сонсогчдод хэлэх ёстой зүйлийнхээ гол санааг хэрхэн хүргэх чадвараа ахиулна. Хүмүүсийн өгсөн санал зөвлөмжийн дагуу судалгаагаа засдаг сайжруулдаг, өөрт дүгнэлт хийдэг чадвараа хөгжүүлнэ. Мөн бусдад бүтээлч зөвлөгөө өгч, ганцаараа, бүлэгт ажиллахдаа ч зорилготойгоор ажиллаж сурна. Сонсох, дүгнэлт хийх чадвараа сайжруулна. Бусад бүлгүүдээр үзэл бодлоо хэлэлцүүлэх, илтгэх зүйлийнхээ агуулга төлөвлөгөөгөө танилцуулах, байр сууриа хадгалах, асуулт тавих, хариулах, нотлох, асуудлыг шийдэх арга барил, мэдлэг чадвараа сайжруулсан байхаар үнэлгээг төлөвлөх нь чухал. Энэ суралцахуйн зорилтын хүрээнд сурагчдын шүүмж бичвэрүүдийг унших, тусган эргэцүүлэх, хэлэлцэх болон хариулахад туслах нь зүйтэй. Хамгийн гол нь сурагчид уг бичвэр дээр өөрийн өнцгөөс харж шүүмжилсэн хариултаа илэрхийлж сурахад чиглэнэ.

Уран зохиолд байнга эргэлзээ төрүүлж байдаг таамаглал, үзэл санаа, хүүрнэл бүтэц гэх мэт байдаг. Энэ нь сурагчдад өөрийн өнцгөөс харж санаагаа илэрхийлэх боломжийг олгож байдаг. Багш ахлах ангийн сурагчдын шүүмжлэх ба задлан шинжлэх авъяасыг хөгжүүлэхийн тулд илүү ахисан түвшний даалгавар гүйцэтгүүлэх хэрэгтэй гэсэн үг. Сурагчдын ярих чадварыг үнэлэх үнэлгээний хувилбарт хүснэгтийг санал болгож байна. Үүнд:

**Хувилбар 1**

Шинэ санаа дэвшүүлсэн эсэх (1-5 оноо)	Зохиолоос хоёроос доошгүй шилэл баримтаар баталсан эсэх (1-5 оноо)	Судлаачдын санааг нотолгоо болон эсрэгцүүлэх баримт болгож чадсан эсэх (1-5 оноо)	Бусдын анхаарал татахаар сонирхолтой байсан эсэх (1-5 оноо)

**Хувилбар 2**

Зохиол болон судалгаанаас олж авсан мэдлэг, ойлголт, сонин содон зүйлийг өөрийн санаа бодлоор баяжуулж ярьсан эсэх (1-5 оноо)	Утга зохиолын нэр томьёо ашиглан, нотолж баталж ярьж, хариулсан эсэх (1-5 оноо)	Санаагаа үндэслэлтэй, тодорхой танилцуулсан эсэх (1-5 оноо)

**Хувилбар 3**

№	Үнэлгээний асуулт	Хааяа	Ихэвчлэн	Дандаа
1	Мэтгэлцэж байгаа сэдэвт тохирсон ихэвчлэн шинэлэг, оновчтой нотолгоог гаргадаг эсэх			

<sup>5</sup>Боловсролын хамтын ажиллагаа нийгэмлэг "Багшийн зөвлөмж", Уб., 2013 он, 13-р тал



2	Гаргасан нотолгоогоо хамгаалж чаддаг эсэх			
3	Нотолгоо нь илтэд буруу байгааг хүлээн зөвшөөрч чаддаг эсэх			
4	Нотолгоог няцаахдаа үндэслэлтэй, үнэнд илүү ойр эшлэл, жишээг сонгож чаддаг эсэх			
5	Тодруулга хийх үед тавьж байгаа асуулт нь учир шалтгааныг илрүүлэхэд чиглэж байгаа эсэх			
6	Бусдын гаргасан саналд хүлээцтэй, хүндэтгэлтэй хандаж байгаа эсэх			
7	Бусдыг хүлээцтэй сонсож, үзэл бодлоо цэгцтэй, баримттай илэрхийлдэг эсэх			

<p><b>12.36.</b> Зохиолын үг хэллэг, уран дүрслэл, яруу хэрэглүүрээс суралцан, уран сайхнаар илтгэх</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Зохиолуудаас уран дүрслэл, яруу хэрэглүүрийг түүвэрлэх</li> <li>- Түүвэрлэсэн уран дүрслэл, яруу хэрэглүүрийн үүргийг тайлан тайлбарлах</li> <li>- Зохиол дахь уран дүрслэл, яруу хэрэглүүрийг ойролцоо утгатай үг хэллэгээр солин найруулах боломжийг судлах</li> <li>- Орчин, дүрийг гаргахдаа өвөрмөц содон ямар үг хэллэг хэрэглэснийг тайлан тайлбарлах</li> <li>- Уншсан зохиолынхоо орчин, дүрийг сонгон авч илтгэл бичих сэдвээ сонгох</li> <li>- Уран сайхнаар илтгэх арга барилд суралцах</li> </ul>	<p>Сурагчдын илтгэж ярьж, бичиж хэвлүүлсэн жишээ загвар</p>
---	---	---

**Багшийн анхаарах зүйл:**

: 12 дугаар ангийн сонсох- ярих чадварын суралцахуйн нэг зорилт нь энэ. Энэ нь “Зохиолын хэл найруулга, уран дүрслэл, яруу хэрэглүүр, бичил дүрслэлийн уншигчдад үзүүлэх нөлөөг дүгнэх, үнэлэх 12.2ж суралцахуйн зорилттой нягт холбоотой.

Уран зохиолын хичээлийн өнөөгийн байдлыг харахад сурагчдын сонсох-ярих чадварыг хөгжүүлэх хичээлийг орхиод байгаа нь харагддаг. Ялангуяа төгсөх ангийн сурагчдын хувьд нийтийн монгол хэлний шалгалт болоод ЭЕШ- д бэлтгэх хичээл болж хувирдаг нь нууц биш. Суралцахуйн энэ зорилтын хүрээнд хичээл заасны дараа асуудал дэвшүүлсэн илтгэл бичих сэдвийн жагсаалт гаргаж, сонголтыг өргөжүүлэхэд багш анхаарлаа хандуулах хэрэгтэй. .

Үлгэрлэвэл:

- Хэлдгийн биш хийдгийн ажлыг үнэлэх ёстой
- Ажил хөдөлмөрийн амт үгээс биш үйлдлээс харагддаг \Элбэг дээл\
- Монгол өвгөд
- Ухааны болоод сэтгэлийн тамиртай өвгөд минь
- Биеийн бөхөөр нэгийг, сэтгэлийн бөхөөр мянгыг \Өвгөн шувуу, Бууж мордох хорвоо\
- Хүний тус ил байх албагүй
- Сэтгэлээс өгсөн тус \Бууж мордох хорвоо\
- Тамгагүй төр бол хаангүй төр
- Төр бол хаан
- Хүн таних монгол ухаан \Тамгагүй төр\

Ийм маягаар жагсаасан илтгэлийн сэдвүүдээс сурагчид өөрсдөө сонголтоо хийх юм. Тухайн сэдэвтэй холбоотой материал цуглуулахдаа уншсан зохиолынхоо дүр, орчинтой холбоотой яруу хэрэглүүр, уран дүрслэлийг ашиглаж болохыг сануулахаа мартав аа. Үлгэрлэвэл: “ Тамгагүй төр бол хаангүй төр” сэдвийн хүрээнд Арчуг, Эгэрэг, Ачирын дүрийг тулгуур болгож авч болно.

Монголчууд хаан хэмээн төрөө, төр хэмээн хаанаа төсөөлдөг. Хаан төр хоёр нэг илэрхийлэл байсан тухай жишээ баримт авч болно. “Монголын нууц товчоо”, “Мандухай сэцэн хатан” гэх мэт.

Өгсөн сэдвээр судалгаа хийж, олон нийтэд уншиж сонсгохоор бэлтгэсэн эхийг илтгэл гэдэг Илтгэл яг ийм байх ёстой гэсэн бэлэн жор байхгүй ч шалгуур үзүүлэлтийг хангасан илтгэл бичихэд суралцагч суралцах ёстой.. Илтгэл бичих дарааллыг хамгийн энгийн байдлаар харуулъя.

**Илтгэл бичих:**

- Сэдвээ сонгох (Ерөнхий сэдвийг дэд сэдэвт хуваах)
- Зорилгоо тодорхойлох
- Шаардлагатай материал цуглуулах
- Төлөвлөгөө гаргах
- Илтгэлийн бүтцээ гаргах
- Бүтцэд хамаарах агуулгаа багцлах
- Агуулгад хамааралтай баримтаа цэгцлэх
- Илтгэлээ ноороглох
- Агуулгыг уран дүрслэл, яруу хэрэглүүрээр баяжуулж бичих
- Бичсэн илтгэлээ нарийн нягталж бэлэн болгоно. (цаасан хэлбэрээр)

Одоо бичсэн илтгэлээ бусдад хүргэх арга замаа сонгох шаардлага гарч ирнэ. Илтгэлээ шууд ярих уу, тулгуур дохио, бүдүүвчийг самбарт бичээд тэр хүрээндээ ярих уу, эсвэл PPT бэлтгэх үү? гэдгээ шийднэ.

**Илтгэл PPT болгож бэлтгэх:**

- Үргэлжилсэн үзээр PPT бэлтгэхээс зайлсхийх
- Нэг слайдад хөндлөн тийш 5-6 үг, доошоо 4 мөр бичвэр байх тухай ч ярьдаг.
- Үсгийн фонд хамгийн багадаа 24 байх ёстой.
- Түлхүүр үг-тулгуур дохио гэдэг зарчмыг баримтлах
- Тулгуур дохио болгох үүднээс PPT- ээ бэлтгэж, анимейшн хийх
- Нэг цогцолборын агуулгыг хэрхэн гаргахаа төлөвлөх
- Анимейшн хийхдээ нэг агуулгын хүрээнд хэдэн хүснэгт бичвэр зэрэг гарч байж агуулга гарах вэ , эсвэл цуварч гаргаснаар тухайн агуулгаа гаргах уу гэдгийг анхаарах хэрэгтэй.

Орон

Орчин

Цаг

Эхлээд орчин гэсэн бичвэр бүхий дүрс, дараа нь орон, цаг гэсэн бичвэр бүхий дүрс зэрэг гарч ирэх нь илтгэл сонсож байгаа хүмүүст ойлгомжтой болж чадна.

- Хугацаагаа тооцож, PPT- нийхээ слайдны тоог гаргах

**Хэрхэн илтгэх вэ?:**

- Сонсогч, үзэгчдийн анхаарлыг өөртөө татахуйцаар мэндлэх
- Сэдэв, зорилгоо танилцуулах
- Дуу өнгөө нэгэн хэвийн байхаас зайлсхийх
- Зогсоц хийх
- Сул үг хэрэглэхгүй байх
- Танхим дүүрэн хараатай бай
- Илтгэлийн төгсгөлийг өвөрмөц содон хий

Ярих-сонсох чадварыг үнэлэх шалгуур	Маш сайн	Сайн	Сайжруулах шаардлагатай
Зохиолын үг хэллэг, уран дүрслэл, яруу хэрэглүүрийг таньж сонгож чадсан уу?			
Таньж сонгосон үг хэллэгээ дуурайн, эсвэл шууд хэрэглэн илтгэж чадсан уу?			
Уран дүрслэлийн аргыг хэрэглэн илтгэж чадсан уу?			
Илтгэхдээ бусдын сонирхол, анхаарлыг татаж чадсан уу?			
Илтгэхдээ өөртөө итгэлтэй байж, дуу хоолойныхоо өнгө, хурдаа тохируулсан уу?			

(СОНГОН СУДЛАХ АГУУЛГА)

НЭГ. УНШИХ ЧАДВАР

Суралцахуйн зорилт	Үйл ажиллагаа	Хэрэглэгдэхүүн
<p><b>12.1а.</b> Монголын шилдэг уран зохиол ба тэдгээрийн хувиргасан бүтээврийг уншиж, төрөл зүйл, зохиогч уншигчийн холбоо хамаарлыг ойлгох</p>	<ol style="list-style-type: none"> <li>1. Тайз, дэлгэцийн уран бүтээлийн талаар санал бодлоо солилцох</li> <li>2. Монголын шилдэг уран зохиолын ямар төрөл тайз дэлгэцийн уран бүтээл болсныг баримтаар нотлох</li> <li>3. Жүжиг, кино \тайз дэлгэцийн уран бүтээл\-ны ялгааг жишиж харьцуулах</li> <li>4. Жүжиг урлагийн бусад зүйлтэй хэрхэн яаж холбогддог болохыг театрт үзсэн жүжиг дээр тулгуурлан ярилцах</li> <li>5. Зохиол, үзэгч уншигчийг холбох гуравдагч зүйл нь жүжигчид байдаг талаар ярилцах</li> <li>6. Идэвхтэй дүрийн үүрэгтэй байдаг 1 дүгээр биеийн хүүрнэн өгүүлэгчийн үг, дүрүүдийн хэлж, бодож, хийж байгаа бүх мэдээллийг дамжуулж байдаг 3 дугаар биеийн хүүрнэн өгүүлэгчийн үг хувиргасан бүтээлд хэрхэн өөрчлөгддөг болохыг баримтаар нотлох</li> <li>7. Зохиолч, төрөл зүйл, уншигч, үзэгчийн холбоо хамаарлыг илэрхийлэхэд хувиргасан бүтээлийн нөлөөллийг өөрийн өнцгөөс тодорхойлох</li> <li>8. Унших дуртай зохиол нь тайз дэлгэцийн уран бүтээл болсныг үзэж сонирхоод, мэдрэмж сэтгэгдлээ илэрхийлэх</li> </ol>	<p>-Г. Нандинбилиг “Хүүрнэл зохиолыг задлан шинжилж сургахуй” УБ 2016 он.</p> <p>-Г.Нандинбилиг “Жүжгийг задлан шинжилж сургахуй” УБ 2013</p> <p>-С.Энхбаяр</p> <p>Утга зохиолын онол</p> <p>УБ.,2008</p> <p>-Г.Аюурзана</p> <p>“Утга зохиолын тухай яриа” УБ., 2004</p> <p>- Ч.Лодойдамба “Тунгалаг Тамир” (1961-1965)роман</p> <p>- “Тунгалаг Тамир” кино</p> <p>- Ч.Долгорсүрэн “Тунгалаг Тамир” романыг кино болгосон тухай- Ч.Долгорсүрэн. “Ч.Лодойдамбын тухай дурсамж”. УБ., 1986</p> <p>- Т.Дүгэрсүрэн “Чадраабалын Лодойдамб1917-1970а намтар зохиол. УБ., 1982</p>

Багшийн анхаарах зүйл:

*Хувиргасан бүтээл нь уран зохиолын төрөл зүйлийн тухай ойлголттой салшгүй холбоотой.*

*Төрөл / genre of literature/ Уран зохиолын бүтээл туурвилыг зохиомж, дүрслэх арга, дүрийн систем, байгуулалт, хэмжээ, бүтэц хэлбэрийн тогтвортой давтагдах шинжээр нь хуваах үйл явц болохыг сайтар ойлгох нь чухал юм.*

- *Туульсын Роман, тууж, өгүүллэг, туурь, лүгээр, домог, хууч яриа, шог яриа/*
- *Уянгын*
- *Жүжгийн төрөл зүйлийн ялгааг сайн ойлгосноор хувиргасан бүтээл ямар төрөл дээр түгээмэл яригддаг болохыг ойлгож авна.*

*Орчин цагийн утга зохиол судлалд уншигчийн оролцоог чухалчилдаг болсны нэг илрэл нь тайлан тайлбарлах арга зүй юм. Туульсын уран зохиолыг тайлан тайлбарлах арга барилд сургахын тулд дүр, орчин, утга санааг задлан шинжлэх даалгаарыг гүйцэтгүүлэх нь зүйтэй. Яруу найргийг тайлан тайлбарлахдаа айзам эгшиглэл, уран дүрслэл, бадаглалд төвлөрдөг. Жүжгийн зохиолыг задлан шинжлэхдээ туульсын уран зохиолын нэг адил өгүүлэгдэхүүн бүтэц, дүр орчноос гадна харилцан яриаг анхаарах нь зүйтэй юм*

<p><b>12.16.</b> Эх зохиол ба хувиргасан бүтээлийн сэдэв, утга санаа, хам сэдэв, дүрийг харьцуулах</p>	<ol style="list-style-type: none"> <li>1. Эх зохиолыг бүрэн эхээр нь уншуулах</li> <li>2. Тухайн эх зохиол хувиргасан бүтээл болсон эсэх талаар судалгаа хийх</li> <li>3. Эх зохиол ба хувиргасан бүтээлд ялгаатай байдал гарч болох эсэхийг судлах</li> <li>4. Сэдэв, утга санаа, хам сэдэв өөрчлөгдөх боломжтой эсэх талаар санаа бодлоо солилцох</li> <li>5. Эх зохиол дахь дэлгэрэнгүй дүрслэлийг тайз дэлгэцийн бүтээлд хураангуйлах тохиолдол байх эсэх дээр санаа бодлоо солилцох</li> <li>6. Театрын харилцаа бичвэрийн харилцан хамаарлын талаар ярилцах, үзэл бодлоо илэрхийлэх</li> <li>7. Харилцан яриа дуу хоолой, үйл хөдлөл, дохио зангаагаар амилж байж дүр үзэгчдийн сэтгэлд буудаг гэдгийг баримтаар нотлуулах</li> <li>8. Зохиолоос авсан хэсгийг тайзны бүтээл болгох дасгал ажиллах\ үглэл яриа, горим зэргийг судлах</li> </ol>	<ul style="list-style-type: none"> <li>- “Тунгалаг тамир” роман</li> <li>- “Үер” тууж</li> <li>- “Харанхуй хад”</li> <li>- “Газар шороо”</li> <li>- “Цахилж яваа гөрөөс”</li> <li>- “Хярааны хонхорт”</li> <li>- “Би чамд хайртай”</li> </ul>
--	---	---

**Багшийн анхаарах зүйл:**

*Нийслэлийн сургууль багш сурагчдын хувьд сонгоны энэ суралцахуйн зорилтыг шийдвэрлэх боломж орон нутгийн сурагчдаас давуу. Хөдөө орон нутгийн сургууль багш нарын хувьд энэ асуудлыг хэрхэн шийдэх вэ гэдэг нь багш нарын санаачилгаас хамаарна.*

Үлгэрлэвэл: 12 дугаар ангийн заавал судлах зохиолд багтах Б.Лхагвасүрэнгийн “Тамгагүй төр” жүжгийн эх зохиолыг уншуулах. Хувиргасан бүтээл болсныг ДУЭТ- т очиж найруулагч Найдандоржийн найруулсан “ Тамгагүй төр” жүжгийг үзсэнээр батлах

- Эх зохиол болоод тайз дэлгэцийн бүтээлийн харилцан ярианы онцлогийг жишиж харьцуулах
- Эх зохиол дахь ямар дүрслэл тайз дэлгэцийн бүтээлд горим болдог талаар судлах
- Дүрийг тодруулахад нөлөөлөхүйц хувцас хэрэглэл, өмсгөл зүүсгэл нь эх зохиол болоод тайз дэлгэцийн бүтээлд ямар ялгаатай илэрч болохыг харьцуулах
- Эх зохиолыг тайз дэлгэцийн бүтээл болгоход найруулагчийн үүрэг нь юу вэ гэдгийг жишин харьцуулж, дүгнэлт гаргах

Бичвэр дэх дүрүүдийн хоорондын харилцан яриа, хэлэх үгийн утгаас дүрүүдийн зан төрхийг олж хардаг бол жүжгийн хувьд дүрүүдийн хоорондын харилцан яриаг сонсож, үйл хөдлөлийг нь харж, дүрээ тодорхойлж байдаг. “Хажуу тийш”, “ Үзэгчдэд хандан” зэрэг горим нь тайзан дээр дүрийн үйлдэл болж байгааг харьцуулах.

Д.Мягмарын “Үер” тууж, “Хүний сайхан сэтгэл “ киног харьцуулах. \Суурь боловсролын хөтөлбөрийн 9 дүгээр ангид үзэж судлах зохиол. \ Эх зохиолд дүрслэгдсэн өвгөний дүр кинонд ямар байдлаар дүрслэгдсэн байгааг харьцуулах

Зохиолоос авсан бичвэрийг тайзны бүтээл болгох дасгал ажиллуулах нь хичээлийг сонирхолтой болгоод зогсохгүй олж авсан мэдлэгээ чадвар болгоход нь түлхэц болно. Үлгэрлэвэл:

**... хоёр гараа давхарлан саравчлан харах гэж оролдовч хар бор ажилд мойнийж, тойнийгоод хоорондоо хэдийнээ эвлэхээ больсон хуруунуудын завсраар нарны туяа сийгэн, нүүрэн дээр нь тусахад өөрийн эрхгүй нүдээ анин, “Муу алга маань нарны туяа ч хааж чадахгүй, шүүрэн шанага шиг сад тавих болов шив” гэж шивээнэнэд “Тэр лав миний муу бирвааз мөн дөгөө” гэсэнэ нар салхинд гандаж онгосон задгай энгэртэй даалимбан цамцныхаа том том мөнгөн товчийг мултлан хүлхгэр цамцаа тайлан нямбайлан эвхээд, салхинд хийсгэн алдахаас болгоомжлон, довон дээр тавиад орхисон хоёр том гутлынхаа хооронд хавчуулан зөрүүлж тавиад, босоход түүний янхигар цээжний хавирга сүврэг арьсныхаа цаана зуралзан хөдөлж, бүр хэнхдэг цээжийг халхлах юмгүй болоод ч тэр үү, нүд далдрим атлаа нэн сүртэй ажээ... гэсэн хэсгийг тайзны бүтээл болгоходоо шивнээ яриаг яаж илэрхийлэх, өвгөний хийж байгаа үйлдлийг хэрхэн үзүүлэх, насны онцлогийг яаж харуулах, сэтгэл санааны байдлыг гаргахад хөгжим ямар үүрэгтэй байх талаар ярилцаж бэлтгэнэ.**

<p><b>12.1в.</b> Эх зохиолын бүрэлдэхүүн хэсгийн холбоо хамаарлыг шинжлэн тайлбарлах</p>	<p>1. Эх зохиолын бүрэлдүүлбэр бүрийн \үйл явдал, өгүүлэгдэхүүн, дүр, орчин, хэл, сэдэв санаа, хам сэдэв\ бүрээр задлан шинжлэх</p> <ul style="list-style-type: none"> <li>- Жүжгийг уншаад, дүр бүрийн зорилго, зорилгодоо хүрэх үйл ажиллагаанд нь дүгнэлт хийх, зохиолчийн үзэл санааг дүртэй холбон тайлбарлах, зан төрхийг тодорхойлох</li> <li>- Үйл явдалд өрнөж буй орчныг тодруулж, дүрүүдийн хоорондын харилцааны уур амьсгал, тэдний амьдрах нөхцөл байдлыг зохиолч</li> </ul>	<p>С.Жаргалсайхан “Хаан түүх” Ц.Балдорж “Хэрээнүүд” 1989 Д.Урианхай “Хүн бүгд би” Б.Лхагвасүрэн “Тамгагүй төр” Б.Догмид “Босоо ороолон” 1988 П.Баярсайхан “Сармагчин бол сармагчин” \1988\ С.Дулам “Цэнхэр тэрлэгт”\1990\ Д.Норов “Үхэл хүлээх газар” 1990</p>
--	---	--

	<p>ямар зорилгоор хэрхэн бүтээснийг тайлбарлах</p> <ul style="list-style-type: none"> <li>- Зохиолын хэлний онцлогийг үг, өгүүлбэрийн сонголт болон хэрэглээн дээр, зохиолчийн уран сайхны сэтгэлгээн дээр тулгуурлан тодорхойлох</li> <li>- Өгүүлэгдэхүүний дэс дарааг тодруулах, ямар зорилгоор зохиолч эхлэл, зангилаа, өрнөл, зөрчил, тайлал зэргийг бүтээснийг эргэцүүлэн, жишээ татан тайлбарлах</li> <li>- Түгээмэл зохиомжийн онцлог болох харилцан яриаг ажиглан уншаад, зохиолчийн зорилгын үүднээс таамаглан дүгнэлт гаргах</li> <li>- Зохиолч нийгмийн, соёлын, шашны, намтрын хам сэдвийг хэрхэн хөндөж, үйл явдлыг бүтээснийг дүгнэх</li> </ul> <p><b>2.</b> Бүрэлдүүлбэрүүдийн холбоо хамаарлыг шинжлэх. Шинжлэхдээ дараах асуултыг хэрэглээрэй.</p> <ul style="list-style-type: none"> <li>- Ямар сэдвээс шалтгаалан ямар дүрийг зохиолч бүтээв? Өөрөөр хэлбэл зохиолч ямар асуудлыг хөндөв? Хөндсөн асуудал нь дүрийг бүтээхэд хэр нөлөөлөв?</li> <li>- Дүрийн амьдрах орчныг, сонголт хийж амьдарч байгаа газар орныг, байр байршлыг зохиолч ямар зорилгоор бүтээсэн бол? Тухайлбал, хэсэг бүрд гарах орчныг “Яагаад зохиолч үйл явдлыг энд... өрнүүлж байгаа юм бол? Энд байснаар дүрүүдийн үзэл санаа тодорч байна уу?” гэж бодох хэрэгтэй.</li> <li>- Зохиолч дүрээ бүтээхдээ ямар үгийг онцлон сонгов? Сонгосон үг нь дүрийн зан чанар, дотоод сэтгэл, хүсэл, үзэл санааг тодруулахад нөлөөлж чадсан байна уу? Ямар дүрслэлийн арга маягийг хэрэглэв? Хэрэглэсэн ур маягууд нь зохиолыг уран болгоход нөлөөлсөн үү?</li> <li>- Үйл явдлыг дараалан бүтээхдээ зохиолч дүрийнхээ өсөлт, бууралтыг хэрхэн зохиов? Дүн шинжилгээ хийнэ үү.</li> </ul>	<p>Ц.Түмэнбаяр “Цагаан сүүний домог”</p> <p>До. Цэнджав “Алтан жүн жор”</p> <p>Ц.Мухар “Цөөх хайрхан”</p> <p>С.Анударь “Бүх юм”</p> <p>Л.Өлзийтөгс “Аквариум” \2002\</p> <p>Д.Батбаяр “Цахилж яваа гөрөөс”</p> <p>Ч.Галсан “Аянгат цагийн тууж”</p> <p>Д.Норов “Тэжээвэр”</p> <p>До.Цэнджав “Хөх жавар”</p>
--	---	---

	<p>3. Шинжилснээ бусдадаа тайлбарлан ярих, хэлэлцэх</p> <p>“Зохиолч ...ийм утга санааг уншигчдад хэлэхийн тулд ...дүрүүдийг бүтээсэн нь оновчтой байна. Тухайлбал энэ өгүүлбэрийг жишээ татан тайлбарлая” гэх мэт Эндээс дүр утга санаа гэсэн хоёр ойлголт их холбоотой юм байна. Мөн дүрээ тодруулахдаа зохиолч ...ийм орчныг бүтээсэн нь их оновчтой байна. Учир нь ...тэрхүү орчинд ингэж амьдарсан учраас утга санаа нь илүү тодорч байна. Зохиолч бүрэлдүүлбэрүүдийн холбоо хамаарлыг их сонирхолтой гаргажээ гэх мэт”</p>	
--	---	--

**Багшийн анхаарах зүйл:**

Эх зохиолын бүрэлдэхүүн хэсгийн холбоо хамаарлыг шинжлэн тайлбарлах чадварыг хөгжүүлэхийн тулд багш “зохиолын бүрэлдэхүүн хэсэг гэж юу болох, тэдний холбоо хамаарал гэдгийг яаж харах, хэрхэн шинжлэх талаас сайн ухаарч бодож, хичээлээ төлөвлөнө. Бид суурь боловсролын түвшинд болон заавал судлах агуулгаар зохиолын бүрэлдэхүүн хэсэг гэдэгт “Дүр, орчин, зохиолын хэл /уран дүрслэл, хэлний хэрэглээ/, зохиолын бүтэц /зохиомж, өгүүлэгдэхүүн/, зохиолын сэдэв, санаа” таван гол бүрэлдүүлбэрүүдийг авч үзэн, зохиолыг задлан шинжилж, туршсан билээ. Харин сонгоны агуулгаар эдгээр бүрэлдэхүүнүүдийн холбоо хамаарлыг шинжлэх гэсэн нэлээн өргөн хүрээнд хийх чадварыг эзэмшүүлэхийг зорьж байна. Энэхүү суралцахуйн зорилт хэрэгжсэн эсэхийг дүгнэх дараах шалгуурыг хэрэглэж болно.

Тайлбарлахдаа	<ul style="list-style-type: none"> <li>- Зохиолоос жишээ баримт татаж байна уу?</li> <li>- Татсан жишээ нь оновчтой байна уу?</li> </ul>
Шинжлэхдээ	<ul style="list-style-type: none"> <li>- Бүрэлдэхүүн хэсэг бүрийг задлан шинжилсэн үү?</li> <li>- Холбоо хамаарлыг шинжлэх асуултад оновчтой хариулсан уу?</li> </ul>

<p><b>12.1г.</b> Эх зохиол ба тэдгээрийг хувиргасан бүтээлийн хэлний хэрэглээ буюу уран дүрслэл, яруу хэрэглүүр, бичил дүрслэлийн уншигчдад үзүүлэх нөлөөллийг харьцуулах</p>	<p>Энэ суралцахуйн хүрээнд сурагчид эх зохиол ба тэдгээрийг хувиргасан бүтээлийн хэлний хэрэглээ буюу уран дүрслэл, яруу хэрэглүүр, бичил дүрслэлийн уншигчдад үзүүлэх нөлөөллийг харьцуулна.</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Зохиолын үг хэлний сонголтыг тайлбарлах, дүгнэх</li> <li>2. Дүрслэх хэрэглүүрийг судлах, дүгнэх</li> <li>3. Зохиолын үг хэлний сонголт уншигчдад үзүүлэх нөлөөллийг харьцуулах</li> </ol>	<p>Ч.Лодойдамба “Тунгалаг Тамир” роман, Кино зохиолыг бичсэн Ч. Долгорсүрэн, Р. Доржпалам найруулагч, Р. Доржпалам нарын “Тунгалаг Тамир” кино, Б.Лхагвасүрэн “Тамгагүй төр” жүжиг, найруулагч Ч.Найдандоржийн найруулсан “Тамгагүй төр” жүжиг, Д.Норов “Эцсийн тушаал” жүжиг, “Эцсийн тушаал” теле жүжиг зэргийг харьцуулах</p>
---	---	--

**Багшийн анхаарах зүйл:**

Суралцахуйн энэ зорилтыг хэрэгжүүлэхдээ үгийн гүн утга, өнгө аясыг ойлгох чадварыг сурагчдад эзэмшүүлж, түүнийг дээд зэргээр хөгжүүлэх нь роман болон жүжгийн зохиол дээр

ажиллах өмнөх ангиудын чадвараас ахисан чадвар байх болно. Ахлах ангийн сурагчдын томоохон зохиол дээр ажиллах чадвар нэлээд гүнзгийрсэн, задлал хийх чадвар ч сайн, бие даан судлах чадвар нь илүү хөгжсөн байдаг сайн талтай.

Ахлах ангийн сурагчид хоёр болон түүнээс олон зохиолуудыг холбож харах ба харьцуулан шүүж, үнэлэлтээ танилцуулахдаа ч сайн байдаг тул аль болох харьцуулах чадварт анхаарах хэрэгтэй. “Гарын ур, сэтгэлийн ур, ухааны ур гурав нийлж байж гэмээн уран болдог” гэсэн монгол сайхан үг бий. Тэгвэл аливаа зохиолд энэ гурван ур хэрхэн нэгдэж уран яруу болсныг нээх урлагт сурагчдаа сургах нь чухал юм. Төрийн шагналт зохиолч Д.Батбаяр “Уран зохиолын бүтээл туурвилыг хэрхэн шалгах вэ? Шалгахад нэлээд ярвигтай нь уран зохиол. Хөгжим зурагтай адил тэр дор нь зохирол, зохиомжийг шалгачих боломж муу. Хэн нэгэн уран зохиол судлаач юм уу, зохиол бүтээлийг нарийн сайн ойлгодог зохиолчид уншуулна гэдэг найдвар багатай хувилбар төдийгүй үр дүн нь тэр хүний тухайн өдрийн сэтгэл санааны байдал, язгуур араншин, төрх зэрэг хажуугийн нөхцөл шалтгаанаас болоод үнэн зөв шалгуурт хүрэхээс илүү тухайн үеийн сэтгэгдэл давамгайлсан үр дүн гарах нь олонтаа” гэжээ. Тэгээд шалгуур нь цаг хугацаа юм гэж дүгнэсэн байдаг тул сурагчдад уншуулахаар сонгосон бүтээлүүд нь цаг хугацаагаар шалгагдсан сайн зохиол байхаас гадна сурагчдын үнэлгээ дүгнэлт ч гэсэн хуудуутай байж болохыг сайн ойлгуулж өөрсдийн санаа, дүгнэлтийг бусадтай сайн ярилцаж, өөрөө байнга эргэцүүлж, Д.Батбаяр гуайн хэлснээр “өнхрүүлэх” хэрэгтэйг сайн ойлгуулах. Мөн багш нар өөрсдийн үзэл бодлыг тулган хүлээлгэх, хүүхдийн санааг хэт баталж нотлох үгүйсгэх нь тийм ч оновчтой биш тул олон санааны уулзвар дээр цаашид бодож эргэцүүлэх боломж үлдээн нээлттэй үлдээх нь чухал. Сурагчид уншсан зохиолоо хувиргасан бүтээл буюу тайз дэлгэцийн бүтээлээс үзсэний дараа харьцуулалтыг нэлээд сайн хийдэг тул дараах асуултаар хөтөлж болох юм. Жишээ нь: Б.Лхагвасүрэн “Тамгагүй төр” жүжгийг уншиж судлаад жүжгийг үзсэний дараа эсвэл Ч.Лодойдамба “Тунгалаг Тамир” романыг уншаад киног үзсэний дараа

- ✓ Зохиолын .... дүрийг уншиж байх үед төрсөн сэтгэгдэл, жүжиг(кино)-ийг үзээд төрсөн сэтгэгдэл хоёрын хооронд ямар ялгаа байв? Шалтгаан нь юу вэ?
- ✓ Хэрвээ чи жүжиг(кино)-ийг найруулсан бол...дүрийг аль талаас нь илүү тод томруун гаргах вэ? Яагаад?
- ✓ Хувиргасан бүтээл дээр зарим зүйлийг өөрчилсөн байдаг энэ нь хэр зөв шийдэл байсан бэ? яагаад?
- ✓ Хувиргасан бүтээл дээр орчныг өөрөөр илэрхийлсэн байдаг. Энэ нь хэр оновчтой шийдэл байсан бэ? яагаад? гэх мэтээр ярилцлага өрнүүлж болох юм.

<p><b>12.1д.</b> Тайз дэлгэцийн бүтээлийн үзэгч сонсогчдод үзүүлэх нөлөөллийг үнэлэх</p>	<p>Энэ суралцахуйн зорилтоор тайз, дэлгэцийн бүтээлийн үзэгч сонсогчдод үзүүлэх нөлөөллийг үнэлэх чадварт суралцана. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Уншсан зохиол бүтээлээс сэдэвлэсэн тайз, дэлгэцийн бүтээлтэй танилцах</li> <li>2. Зохиол бүтээл, тайз дэлгэцийн бүтээлийн ижил төстэй ба ялгаатай байдлыг дүгнэх</li> </ol>	<p>“Эцсийн тушаал” теле жүжиг, “Эцсийн тушаал” жүжгийн дуу Чинзоригийн хөгжим, Д.Норовын үг “Хүлээсэн сэтгэлийн дуу” “Тамгагүй төр” жүжиг, “Тунгалаг Тамир” кино</p>
--	--	--

**Багшийн анхаарах зүйл:**

Бид энэ суралцахуйн зорилтыг хэрэгжүүлэхдээ хоёр үйл ажиллагааг санал болгож байна.

Уншсан зохиол бүтээлээс сэдэвлэсэн тайз, дэлгэцийн бүтээлтэй танилцахдаа



Тайз дэлгэцийн бүтээлийг театрт үзэх боломжтой нь театр үзэх, боломжгүй нь цахимаар үзэхийг сурагчдад багш санал болгоно. Ер нь театрт үзэх нь цахимаар үзсэнээс ихээхэн ялгаатай талаас нь тайлбар хийгээрэй. Хичээлийн жилийн эхэнд эсвэл улирлын эхэнд унших зохиолтой холбоотой ямар ямар тайз дэлгэцийн бүтээлүүд хэзээ хаана хаана тоглогдох талаар багш судалгаа хийж, сургалтын төлөвлөгөөндөө тусгах хэрэгтэй. Хөдөө орон нутгийн сурагчдын хувьд телевизор болон цахимаар үзэхээр төлөвлөлт хийнэ. Жишээ нь “Тунгалаг Тамир” кино жилдээ 1-2 удаа телевизээр гардаг тул тэр үед ч сургалтын төлөвлөгөөгөө зохицуулж болох юм.

**Зохиол бүтээл, тайз дэлгэцийн бүтээлийн ижил төстэй ба ялгаатай байдлыг дүгнэхдээ**

Зохиол болон тайз дэлгэцийн бүтээлийг сурагчдын зуны амралтаар өгөөд судалгаа хийж харьцуулан илтгэл тавихад сурагчдын ялгаатай, олон өнцгийн уулзвар дээр дүгнэлт хийх боломж бүрддэг сайн талтай.

Нэгэн сургуулийн жишээн дээр “Тамгагүй төр” жүжгийг үзсэн сурагчид харьцуулсан дүгнэлтийн санааг олсноо илтгэлдээ хэрхэн дурдаж байсныг харъя. “Зохиолыг уншиж байхдаа Ачирт дургүй л хүрч байсан харин жүжгийг үзээд бүр тийм тэнэг гэдгийг хэтэрхий сайн ойлгоод дургүй хүрэх төдий биш үнэхээр үзэн ядлаа. Түүнээс болоод энэ жүжгийн Ачирын талаар дахин уншиж, би юуг үлдээж, сайн анхааралгүй уншив? Найруулагч аль талыг олж харснаар Ачирт үзэгчид тэгтэл дургүй нь хүрэх шалтгаан болгож чадав гэдгийг хайснаараа энэ илтгэлээ бэлтгэсэн”

“Би зохиолын уншиж байхдаа ганц модонд маш их ач холбогдол өгч, үйл явдалд үнэний гэрч болон оролцож байна гэж харж мэдэрч ойлгож уншсан бол жүжигт ганц мод огт гарсангүй нь сэтгэл нэг л тиймхэн байлаа. Тэгээд би илтгэлээ бэлтгэхдээ зохиолд гарч байгаа ганц модны талаар судалгаа хийсэн”

“Хатад төрийг мөхөөхөд ихээхэн үүрэг гүйцэтгэдэг” гэдэг үгийг би төдий л сайн ойлгодоггүй байсан бол энэ зохиолыг уншиж, жүжгийг үзээд маш сайн ойлголоо. Тэгээд би их хатны төрийг мөхөөх аюулд хүргэж байгаа ухаан дутмаг үйлд чиглэж илтгэлээ бэлтгэсэн” гэх мэтээр ярьцааж өөр өөрийн судалгаа, дүгнэлтээ танилцуулж байсан нь санаа авууштай байлаа.

Эсвэл багш асуултаар чиглүүлж болох юм. “Эцсийн тушаал” жүжгийн дуу Чинзоригийн хөгжим, Д.Норовын үг “Хүлээсэн сэтгэлийн дуу”-г сонсоод чамд ямар сэтгэгдэл төрөв? Яагаад? Дууны үг жүжгийн аль аль хэсэгтэй яаж холбогдов? гэх мэт.

<p><b>12.1е.</b> Шүүмжийн санаа, шүүмжлэгчийн үнэлгээ дүгнэлтийг тайлбарлах, үнэлэх</p>	<p>1. Зохиолтой холбоотой шүүмжийг судалж унших</p> <p>Судалж уншихдаа:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Шүүмжийн төрлийн онцлогийг сэргээн санах, юуг шүүмж гэж үздэг талаар санал солилцох, нэгдсэн ойлголтод хүрэх</li> <li>- Шүүмжид зохиолын сэдэв, санаа, орчин, дүр, хэл найруулга, үйл явдал, өгүүлэгдэхүүний бүтэц, хүүрнэлийн учир холбогдол, дуу хоолойны алийг нь онцолж, шүүмж бичсэнийг анхаарах, тодорхойлох</li> </ul> <p>2. Шүүмжлэгчийн зүгээс ямар санаа дэвшүүлснийг олох, тайлбарлах, жишээ татах</p> <p>3. Шүүмжлэгч ямар дүгнэлт өгснийг шүүмжийн бүтцээс олох, дүгнэлт мөн эсэхийг харилцан санал солилцох</p>	<p>-У.Шекспир “Ромео Жульетта”</p> <p>Орчуулагч Ч.Чимэд, Х.Мэргэн</p> <p>-Я.Баяраа “Эдүгээчлэгдсэн эмгэнэл буюу энэ цагийн Ромео Жульетта” шүүмж</p>
---	--	--

	<p>4. Шүүмжлэгч зохиолын юуг онцолж үнэлэв? Үнэлснийг нь яаж мэдэв? Шүүмжээс жишээ татан тайлбарлах</p> <p>5. Шүүмж гэж ямар төрлийг хэлэх, өөрийнхөөрөө томъёолж, дүгнэлт гаргах</p>	
--	---	--

**Багшийн анхаарах зүйл:**

*Шүүмж нь уншигч , уран зохиол хоёрыг холбогч гүүр нь болдог. Тодорхой нэг шүүмж дээр ярилцах хэрэгтэй. Үлгэрлэвэл: Шекспирийн “Ромео Жульетта” зохиолыг уншиж, Наранбаатарын найруулснаар жүжгийг үзсэний дараа СУИС-ийн ТУС-ийн Урлаг судлал, утга зохиолын тэнхимийн баш Я.Баяраагийн бичсэн “Эдүгээчлэгдсэн эмгэнэл буюу энэ цагийн Ромео Жульетта” шүүмжийг ярилцаж болно.. Шүүмжлэгчийн үнэлгээ дүгнэлтийг сурагчийн өөрийнх нь бичсэн шүүмжтэй харьцуулаад , алдааг нь засаж, шинжлэх ухааны ойлголтоос гажсан бол залруулж өгөх нь зүйтэй. Мөн дараах хувилбараар ажиллаж болно.*

1. Сэтгэгдэл бичих, шүүмж бичих хоёрыг ялгуулах
2. Уншсан ном, үзсэн жүжиг, киноны тухай шүүмжийг унших, ухаарч ойлгох
3. Шүүмжийн санаа, өөрийн чинь санаа хоёрт ижил төстэй болон ялгаатай зүй байгааг харьцуулах
4. Шүүмжлэгчийн үнэлгээ, дүгнэлтийг өөрийнхтэйгөө харьцуулж шинжлэх

*Шүүмжид гарч байгаа онолын ойлголтыг багшийн дэмжлэгтэйгээр залруулах, ойлголтын зөрүүгээ арилгах*

*Шүүмж нь уншигч , уран зохиол хоёрыг холбогч гүүр нь болдог. Нэг зохиол уншуулаад шүүмж бичээрэй гэж тулгах нь учир дутагдалтай. Уншиж судалсан зохиолтой холбоотой хэн нэгний бичсэн шүүмжийг уншиж, задлан шинжилсний дараа сурагчдад шүүмж бичих даалгавар өгөх нь зөв. Үлгэрлэвэл: Шекспирийн “Ромео Жульетта” зохиолыг уншиж, Наранбаатарын найруулснаар жүжгийг үзсэний дараа СУИС-ийн ТУС-ийн Урлаг судлал, утга зохиолын тэнхимийн баш Я.Баяраагийн бичсэн “Эдүгээчлэгдсэн эмгэнэл буюу энэ цагийн Ромео Жульетта” шүүмж дээр ярилцах нь зөв санагддаг. Шүүмжлэгчийн үнэлгээ дүгнэлтийг сурагчийн өөрийнх нь бичсэн шүүмжтэй харьцуулаад , алдааг нь засаж, шинжлэх ухааны ойлголтоос гажсан бол залруулж өгөх нь зүйтэй .*

*Мөн Б.Лхагвасүрэнгийн “ Тамгагүй төр” жүжгийн бүрэн эхээр нь уншуулсны дараа задлан шинжлэх даалгаврыг гүйцэтгэнэ. Дараа нь ДУЭТ- т найруулагч Найдандоржийн найруулсан “Тамгагүй төр” жүжгийг үзэх нь зөв.*

*Мөн нэг зохиол дээр бичсэн шүүмжүүдийг харьцуулж дүгнэж болно.Үлгэрлэвэл: Ч.Лодойдамбын “Тунгалаг тамир” романыг бүрэн эхээр нь уншуулсны дараа шүүмжтэй танилцуулж болно. Бүгдийг нь энэ шүүмжүүдийг уншаарай гэвэл хүүхдүүдэд ачаалал их ирэх учир баг бүрт нэг шүүмж өгч, романыг аль талаас нь харж, шүүмжилсэн талаар дүгнэлт гаргуулна.*

*Ч.Лодойдамбын “Тунгалаг Тамир” романы эргэн тойронд:-*

*М.Баянзул “Тунгалаг Тамир” роман ямар санагдана вэ?”*

*Д.Цэдэв “Тунгалаг Тамир”*

*Г.Дүйнхэржав “Тунгалагхан Тунгалаг Тамир”*

*Н.Банзрагч “Тунгалаг Тамир”-аас үүдсэн бодол”*

Г.Жамсранжав “Тунгалаг Тамирыг тунгаан бодоход” гэх мэт

Шүүмжлэгч хувийн шинж зан төрх, амьдралын байр сууриа харьцангуй тодорхой харуулж, үзэл бодол, сэтгэлийн хөдөлгөөнөө /бахархал, дургүйцэл, егөөдөл, зэвүүцэл, уур хилэн г.м/ илүү чөлөөтэй илэрхийлсэн байх нь олонтоо.

## ХОЁР. БИЧИХ ЧАДВАР

Суралцахуйн зорилт	Үйл ажиллагаа	Хэрэглэгдэхүүн
<p><b>12.2а.</b> Зохиолын хэлний хэрэглээг үнэлэх, тайлан тайлбарлаж бичих</p>	<ol style="list-style-type: none"> <li>1. Уншсан зохиолуудаас аль нэгийг сонгох</li> <li>2. Зохиолоос урнаар дүрсэлсэн үг хэллэг, дүрслэлийг таньж сонгох, яагаад уран дүрсэлсэн гэж үзсэнээ тунгаан бодох</li> <li>3. Бичил дүрслэл буюу тэмдэг нэрээр илэрсэн дүрслэлийг таньж сонгох, яагаад бичил дүрслэл гэж үзсэнээ тунгаан бодох</li> <li>4. Зохиолчийн үгийн сонголтыг үгийн сангийн бүрэлдүүлбэрийн талаас ажиглаж, сонгох, зохиолч ямар зорилгоор үг сонгосныг тайлбарлан ярьж, бичихэд бэлдэх</li> <li>5. Хэлний хэрэглээг өөрийн үзэл бодлоороо тайлан тайлбарлахад бэлдэх</li> </ol> <p>Ингэхдээ “Урнаар дүрсэлсэн нь зохиолыг сайн болгосон, бичил дүрслэлийн аргыг хэрэглэснээр уншигчдын сонирхол, анхаарлыг их татсан, үгийн сангийн онцлог нь Монгол ахуйг тусгасан учраас содон байна” гэх мэтчилэн үнэлэн ярих</p> <ol style="list-style-type: none"> <li>6. Тайлан тайлбарлаж ярьснаа жишээгээр баяжуулан ноороглон бичих</li> <li>7. Нооргоо бусдадаа уншуулж, зөвлөгөө авах, саналыг тусгах</li> <li>8. Зөв бичгийн дүрмийн болон утга найруулгын засвар хийх</li> <li>9. Засварын дараа дахин сийрүүлж бичих</li> </ol>	<p>Үг сонголт сайтай, өгүүлбэр зүйн ур маягууд, уран дүрслэлийн ур маягаар уран сайхнаа бүтээсэн, бичил дүрслэл бүхий эх зохиол сонгох</p> <p>Төрбат “Могойн чуулган”1989 Л.Түдэв” Оройгүй сүм”, “Хувьсгал танаа өчье” 1994 Г.Аюурзана “Илбэ зэрэглээ” 2003, “Бөөгийн домог” 2010 До.Цэнджав “Цагаагчин гахай жил” 2010</p>
<p><b>Багшийн анхаарах зүйл</b> Зохиолын хэлний хэрэглээг үнэлэх, тайлан тайлбарлаж бичих чадварт сургахдаа дараах зөвлөмжийг анхаарна уу. Энэ суралцахуйн зорилтыг хэрэгжүүлэхийн тулд орчуулгын зохиолыг судлахдаа орчуулгын чанар, найруулгыг шалгуур болгох шаардлагатай. Тайлан тайлбарлах /интерпретация/ гэдэг нь зохиолыг ойлгох, тусган хүлээж авахтай холбоотой үйл юм. Ойлголтын тухай сургаал, бичвэрээс зохиогч руу судлах ухаан.Уншигч өөрийн үзэл бодлоор хандах, зохиолчоос өөрөөр сэтгэж илэрхийлж болно. Хувь хүний төсөөлөл, мэдрэмж, боловсролоос шалтгаална. Зохиолчийг ойлгох үүднээс зохиолын ил, далд утга, үг, хэлд анхаарлаа хандуулж, нэг бүрчлэн мөрдөж унших хэлбэр. Олон тайлбар шаардах бүр тухайн зохиолын үнэ цэн тодорч болно. “Хэл бол тоглоом” гэж үзвэл зохиолыг уншигч өөрийнхөөрөө тайлж тайлбарлаж болно. Сурагчдаас уншихуй-ойлгохуй-сэтгэхүйн суралцах үйл ажиллагааг шаарддаг ойлголт юм. Хэлний хэрэглээг судална гэдэг нь зохиолчийн зүгээс уншигчдад нөлөөлөхийн тулд хэрхэн холбоо тогтоож байгааг шинжилнэ гэсэн үг. Хэлний хэрэглээ гэдэгт:</p> <ol style="list-style-type: none"> <li>5. Үг сонголт /үгсийн дуудлага-diction, өнгө аяс-tone судлах/</li> <li>6. Өгүүлбэр зүйн ур маягууд /өгүүлбэрийн доторх үгсийн байрлал, яруу хэрэглүүрийн үүргийг судлах/</li> <li>7. Уран дүрслэлийн ур маягийг судлах</li> </ol>		

8. Бичил дүрслэлийг судлах<sup>6</sup> Эдгээрийн тухай ойлголтоо нэмэгдүүлэхдээ Г.Нандинбилиг, “Хүүрнэл зохиолыг задлан шинжилж сургахуй” номыг хэрэглээрэй.

Дэмжлэг болох асуулт:

- Зохиолч юуг хэлэхийг хүсэж, дүрээ бүтээхдээ дүрслэлт үгийг хэрэглэсэн бэ?
- Хэрвээ тухайн үгийг зохиолч сонгож хэрэглээгүй байсан бол зохиолын утга санаа хэр өөрчлөгдөх бол?
- Зохиолч үгийн сангийн бүрэлдүүлбэрүүдээс ямар үгийг ямар зорилгоор сонгосон бэ? Ойролцоо, эсрэг, ижил, хуучин, шинэ, мэргэжлийн, харь, нутгийн аялгууны, этгээд, бүдүүлэг, төсөөт, тонгоруу үг, хэвшмэл ба өвөрмөц үг хэллэг, хэлц гэх мэт
- Урнаар дүрсэлсэн хэсгийг яаж таних вэ? Адилтгасан, хэтрүүлсэн, егөөдсөн, бэлгэдсэн г.м байна уу?
- Жүжгийн зохиолыг уншсан бол цэг тэмдгийг ямар зорилгоор хэрэглэсэн бол?

Зохиолын хэлний хэрэглээг үнэлж, тайлан тайлбарлаж бичихдээ холбогдох нэр томъёог хэрэглээрэй.

Утга найруулгын засвар хийхдээ:

Шалгуур	Тийм	Үгүй	Юуг яаж сайжруулахаа бичээрэй.
Уншихад ойлгомжтой байна уу?			
Үг, өгүүлбэр нэммээр байна уу?			Ямар үг, өгүүлбэр нэмэхээ төлөвлөх
Үг, өгүүлбэр хасмаар байна уу?			Ямар үг, өгүүлбэр хасахаа төлөвлөх
Үгийн байрлалыг солих уу?			Хэддүгээр цогцолборт үгийн байрлалыг солихоо харах, төлөвлөх
Үгийг өөрчлөх үү?			
Баримтын алдаа байна уу?			
Гоо зүйн алдаа байна уу?			
Логик дарааллын алдаа байна уу?			

**12.26.**

Зохиолын тогтсон хэлбэр, зохиомжийг өөрчилж, үгийг чөлөөтэй турших, бүтээл бичих

1. Хэлбэр, зохиомжийг өөрчлөх зохиолоо сонгох
2. Сонгосон зохиолынхоо хэлбэрийг ажиглаж, хэмнэлийг үүсгэж байгаа үг, үсэг, авианы тухай ярилцах, яагаад энэ шүлэг хэмнэлтэй болсон талаар хэлэлцэж, дүгнэх
3. Сонгосон зохиолынхоо зохиомжийг ажиглаарай. Зохиомжийн нэгжүүдээс аль нь илэрснийг ярилцаад, өөрчилж бичих хэсгийг зохиолоос сонгох
4. Үргэлжилсэн хэлбэрийг шүлэглэсэн болгож турших
5. Яаж өөрчилж бичихээ төлөвлөхдөө онолын тодорхойлолтыг баримтлах

Юуг өөрчлөхөө шийдсэний дараа яаж бичихээ дараах алхмын дагуу гүйцэтгэнэ.

- Бичих санаагаа олж төлөвлөх /Юуны тухай бичихээ, ямар асуудал дэвшүүлэхээ бодно/
- Ямар санааг уншигчдад хэлэхийг хүсэж байгаагаа эргэцүүлэн бодох, бусадтайгаа санал солилцох
- Зохиохдоо ямар үгийг сонгож бичихээ бодох, хэлэлцэх

Зохиомж сайтай эх зохиолын хувилбарууд

Үгээр дүрс бүтээсэн эх зохиол байж болно

Үргэлжилсэн хэлбэрийг шүлэглэсэн болгосон хувилбарт зохиол

<sup>6</sup>Г.Нандинбилиг, “Хүүрнэл зохиолыг задлан шинжилж сургахуй”, 2016 он, 44-р тал

	<ul style="list-style-type: none"> <li>- Хэрэв шүлэг бичихээр бол санаагаа цэгцэлж, зөв байрлуулахдаа хэдэн мөр, бадагт санаагаа байрлуулахаа төлөвлөх</li> <li>- Хэрэв үргэлжилсэн үгийн зохиол бол хэчнээн цогцолборт хэдэн санаа гаргаж бичихээ төлөвлөх, догол мөрөөр илэрхийлэхэд анхаарах</li> <li>- Төлөвлөсний дагуу ноороглож бичих</li> <li>- Нооргоо бусдадаа уншуулж, зөвлөгөө авах, саналыг тусгах</li> <li>- Зөв бичгийн дүрмийн болон утга найруулгын засвар хийх</li> <li>- Засварын дараа дахин сийрүүлж бичих</li> </ul>	
<p><b>Багшийн анхаарах зүйл:</b>  Сурагчид уншсан зохиолынхоо зохиомжийн бүрдүүлбэрийг таньж, ялган, зохиолч яагаад ийнхүү зохиомжилсныг тайлбарласны дараа <i>Энэ нь заавал унших 12 дугаар ангийн агуулга юм\ бичүүлэх үйлийг эхлэх хэрэгтэй. Унших хэсэгт байгаа зохиомжийн тухай онолын ойлголтыг хэрэглэхийг санал болгож байна.</i></p>		

## ГУРАВ. СОНСОХ-ЯРИХ ЧАДВАР

Суралцахуйн зорилт	Үйл ажиллагаа	Хэрэглэгдэхүүн
<p><b>12.3а.</b> Орчин үеийн тайз дэлгэцийн зохиолын талаар шүүмжлэл өрнүүлэн мэтгэлцэх</p>	<p>Энэ суралцахуйн зорилтоор орчин үеийн тайз, дэлгэцийн бүтээлийн талаар шүүмжлэл өрнүүлэн мэтгэлцэх чадварт суралцана. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Орчин үеийн тайз, дэлгэцийн шилдэг бүтээлтэй танилцах</li> <li>- Тайз дэлгэцийн бүтээл дэх дүр, орчин ахуйн дүрслэлийн харьцуулал хийж мэтгэлцэх</li> </ul>	<p>“Үер”, “Хүний сайхан сэтгэл”, “Хатанбаатар Магсаржав”, “Мандухай цэцэн хатан”, “Хөдөөгийн баясгалан”, “Хүргэн хүү” зэрэг монголын уран сайхны кино, “Атга нөж” гэх мэт жүжиг</p>
<p><b>Багшийн анхаарах зүйл:</b>  Энэ суралцахуйн зорилтын хүрээнд хоёр үйл ажиллагааг санал болгож байна.  <u>Орчин үеийн тайз, дэлгэцийн шилдэг бүтээлтэй танилцахдаа:</u></p> <ul style="list-style-type: none"> <li>✓ Монголын орчин үеийн тайз дэлгэцийн шилдэг бүтээлийн шүүмж, судлалын талаарх мэдлэг ойлголтоо тэлэх</li> <li>✓ Шүүмжийн ач холбогдлыг таньж мэдэх</li> <li>✓ Тайз, дэлгэцийн бүтээлүүдийг шинжлэх ухааны үндэслэлтэй, мэргэжлийн түвшинд үнэлж дүгнэсэн, онолын үндэслэл сайтай бичигдсэн судалгааны бүтээлүүдээс уншиж мэдэх</li> <li>✓ Өөрсдийн үнэлгээ дүгнэлтээ өгөх зорилго тавина.</li> </ul> <p>Жишээ нь: 2018 оны 7 дугаар сарын 25-нд Улаанбаатар хотноо чуулсан олон улсын монголч эрдэмтэд “Их Эзэн Чингис хааны дүр тайз, дэлгэц, дүрслэх урлагийн бүтээлд хэрхэн дүрслэгдсэн бэ” гэсэн сэдвээр салбар хуралдаан хийсэн талаарх мэдээллийг <a href="https://ikon.mn/n/1cfw">https://ikon.mn/n/1cfw</a> сайтаас уншиж мэдэн өөрсдийн хэлэлцүүлэг мэтгэлцээнд ашиглаж болно. Мөн сурагчид өөрсдөө асуудал дэвшүүлээд түүнийгээ тайз дэлгэцийн бүтээлээс судалгаа хийж болно. Тухайлбал:</p> <ul style="list-style-type: none"> <li>✓ Монгол ахуй, соёл, ёс заншил</li> <li>✓ Монгол өвгөдийн дүрийн онцлог</li> <li>✓ Монгол хатдын дүрийн онцлог</li> <li>✓ Монгол залуучуудын дүрийн онцлог гэх мэт тайз дэлгэцийн бүтээлд хэрхэн дүрслэгдсэн талаар хэлэлцүүлэг хийж болно.</li> </ul>		